

## БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-7
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-48

---

- 1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/** 9-12
- 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 12-23
- 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/** 23-35
- 4. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/** 35-48

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
05 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Батцэцэг, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, С.Одонтуяа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Ч.Лодойсамбуу хэлэлцэх асуудлын дарааллын тавдугаар асуудал болох Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Байнгын хорооны дарга Б.Бейсен уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв. /16:14/

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолыг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

**Б.Бейсен:** “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргав.

Нийт 19 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 63.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчин, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, хуульч, судлаач М.Энхмэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчин, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Р.Сэддорж нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны Иргэдийн Нийтийн хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоногийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Бейсен:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 9  
Бүгд: 19  
52.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх 2 санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Бейсен Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу дахин санал хураалгах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Байнгын хорооны дарга Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувь буюу гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**Б.Бейсен:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Н.Цогтбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Дэчин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, С.Замира, М.Мандхай, Б.Бейсен нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Хүрээлэн буй орчин, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн

газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Мал эмнэлгийн хүрээлэнгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Алтангэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн газрын дарга Т.Гантогтох, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хувьцаат компанийн Төслийн удирдлагын газрын дарга Б.Баярдаваа, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг нар оролцов.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Мандхай, М.Ганхүлэг, П.Батчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон Жанжин Д.Сүхбаатар” танхим  
16 цаг 10 минут.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна. Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн орж ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалд танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”.

Хоёрдугаарт, Байгаль орчинд нөлөөллийн байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Гуравдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028, 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Дөрөв дэх асуудал, “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Тавь дахь асуудал, “бусад” асуудал гээд байгаа. Энэ хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Лодойсамбуу гишүүн үг хэлье.

**Ч.Лодойсамбуу:** Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Энэ өнгөрсөн хуралдаан дээр Байнгын хорооны даргыг сонгохтой холбоотой хуралдаан дээр Ардчилсан намын бүлгээс 5 хоногийн завсарлага авсан. Тэгээд Их Хурлын тухай, чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 3 хүртэлх хоногоор сунгаж болно гэж заасны дагуу яг энэ асуудлаар дахин 3 хоног сунгаж өгөөч гэж Байнгын хорооноос хүсэж байна.

**Б.Бейсен:** Хуралдаанд завсарлага авах 12 дугаар зүйл дээр 12.1-д энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвсэл, бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хурлын даргалагч завсарлагын хугацааг 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэсэн заалттай юм байна.

Тийм учраас 6 дахь асуудал дээр 3 хоногийн завсарлага өглөө. 5 дахь асуудал.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн саналаа хэлсэн тул хэлэлцэх асуудалд оръё.

#### **Байнгын хорооны тогтоолын төсөл “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”**

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 33 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойших хугацаанд төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, Засгийн газраас хариуцан төлж байгаа байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсгол явуулж болно гэж.

Мөн хуулийн 29.2-т Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулна гэж заасны дагуу дээрх сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсныг та бүхэнд хүргүүлсэн.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу?

Ганхүлэг гишүүн асуулт асууя. С.Ганбаатар гишүүнээр тасалъя. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Хөдөө аж ахуйн салбарт бас 2008 оноос хойш олгосон урамшуулал, дэмжлэгүүд, мөн бас сүүлд олгож байгаа зээлийн хүүгийн татаастай холбогдолтой асуудлаар сонсгол зохион байгуулах энэ бас ажлыг санаачилж байгаа Мандхай гишүүнд бас талархал илэрхийлье. Дэмжиж бас гарын үсэг зурсан бас гишүүдийн нэг байгаа.

Цаг хугацааны хувьд 2026 оны 9 сарын 21, 22-ны өдөр гэдэг ийм хугацаа товлож байгаа юм байна. Уул нь хаврын чуулгандаа бас багтаад асуудлуудаа бас яриад явах ёстой байсан уу? Тодорхой бас энэ татаас, урамшуулалтай холбогдолтой сайжруулалтуудыг хийх цаг хугацаагүй бас бид бүхэн бас ер нь болох гэж байгаа ийм нөхцөл байдлууд бас байна. Ер нь ингээд 27, 28 оны сонгуулийн жилүүд бас явахаас өмнө сонсголын үр дүнгээр Засгийн газарт тодорхой чиглэлүүдийг өгч, шаардлагатай бас арга хэмжээнүүдийг авах энэ талаас нь бас харвал аль болох бас наашаа татаж бас зохион байгуулалт хийх нь зөв байсан уу гэдэг ийм асуулттай бас байна.

**Б.Бейсен:** Мандхай гишүүн хариулья.

**М.Мандхай:** Ганхүлэг гишүүнд баярлалаа, бас дэмжиж ажиллаж байгаад нь бас баярлаж байгаагаа бас илэрхийлье. Цаг хугацааны хувьд бол бид нар 2008 оноос хойших бүх татаас, урамшуулал, зээл санхүүжилттэй холбоотой дата мэдээллийг маш сайн нарийн цуглуулж, дээрээс нь бас холбогдох яг энэ үйлдвэрлэл, аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, малчид тариаланчдаас бас холбогдох холбоонуудаас мэдээлэл авахад бас хугацаа орохоор байгаа тул бас яаран бас энэ хаврын чуулганаар дутуу дата, мэдээлэлтэйгээр сонсгол хийх нь бас өөрөө учир дутагдалтай байгаа учраас хуулийн хугацаагаараа бол бид нар 20 хоног бас ард иргэдээс санал авах эрх нээгдэж байгаа.

Дээрээс нь бас дата, мэдээллүүдээ авах энэ хугацаа бол бас хангалтгүй байгаа гэж үзэж байгаа учраас намрын чуулганаар яг бас төсөв хэлэлцэхийн наахан нь гишүүд маань бас тойргоор яваад ирсний дараа Байнгын хорооны ирц бүрэн бүрэлдэх ийм боломж байгаа учраас 9 сарын 28, 29 гэдэг энэ хугацааг бас тооцсон байгаа.

Тэгээд одоо бол бас нийслэлийн төсвийн сонсгол бас орж ирэх гэж байгаа учраас ингээд сонсголууд бас давхацчихсан, хурлууд бас ингээд давхацсантай холбоотойгоор ирц бүрдэх гүй ийм эрсдэл байгаа учраас намрын чуулганд сонсголоо эхэлье гэсэн ийм төлөвлөгөөтэйгөөр оруулж ирж байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулья.

**М.Ганхүлэг:** Төсөв, санхүүтэй холбогдолтой асуудлуудыг бас дахиад сайн та бас хараарай. Энэ 5, 6 сард ерөнхийдөө төслүүд нь бас үндсэндээ боогдоод ингээд дуусчих байх тээ? Тэгэхээр 9 сард бас тодорхой ялангуяа бас 7, 8 төрлийн урамшуулал бас хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа. Энэ дээр тодорхой бас өөрчлөлт оруулах ийм саналууд бас гарлаа гэж бодоход төсөвт бас өөрчлөлт хийх ийм боломж бололцоо 9, 10 сард бас гарах уу үгүй юү? Тэгэхээр ирэх оны бас төсөв бас нэлээн хумигдмал ийм төсөв болох хандлагатай байх шиг байна. Тэгэхээр энэ дээрээ бас жоохон анхаараад, тэр зохион байгуулалтын мэдээлэл цуглуулахтай холбогдолтой асуудал бол 20 хоног байдаг юм уу, тодорхой хугацаандаа ажлын алба багаа бүрдүүлээд ажиллачихад бол их тийм бас төвөггүй

болов уу л гэж би бас бодож байна. Тэгээд энэ дээр боломжтой бол бас эргэж хараад хугацаагаа наашлуулбал яасан юм бэ гэсэн ийм саналтай бас байна.

**Б.Бейсен:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд асуулт асууя.

**С.Ганбаатар:** Энэ Мандхай гишүүний болон бусад гишүүдийн санаачилсан энэ асуудал бол үнэхээр тулгамдсан асуудал аа. Монголын хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн салбар бол бидний хамгийн их ажлын байр бий болгодог, хүмүүсийн амьдралыг тэтгэдэг Монголын үндсэн салбар. Тэгээд энэ дээр сонсгол бол яах вэ тавиу хувь хугацаатай байх нь зөв гэж би үзэж байна.

Яагаад гэвэл энэ том салбар. Суурь шинэчлэлийн алхмуудыг суурь шинэчлэлтэй холбоотой саналууд эндээс гараасай гэж би хүсэж байна. Зүгээр буруутан хайгаад л явах биш гарц гаргалгаа, үр дүн, бүүр цаашилбал холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналууд энэ сонсголоос орж ирж гараасай гэдэг үүднээс би бас нэлээн том үр дүн хүлээж байна. Идэвхтэй би бас дэмжиж байгаа. Идэвхтэй ажиллана. Тэгээд саалиа бэлдэхээр саваа бэлд ээ гэж үг байдаг. Одоо бид ерөөсөө энэ тусламж, дэмжлэг, буцалтгүй тусламж, зээлд хөдөө аж ахуйн салбарт нэмж хэдийг өгөх вэ л гэж бид бодоод байдаг болохоос биш өгч байгаа зүйл маань мафийн гарт орж байна уу, үгүй юү, хулгайн замаар явж байна уу, үгүй юү, ямар ч үр дүнгүй байна уу, үгүй юү, яг авах ёстой жинхэнэ хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын хүмүүс нь тойргийн гадна хаягдаад байна уу үгүй юү? Энэ олон хүмүүстэй уулзаж гарц гаргалгааг нь гаргах гэж л энэ сонсгол, энэ ажлын хэсэг байна гэж би ойлгож байгаа.

Цоорхой сав руу өчнөөн сааль хийгээд нэмэргүй шүү дээ. Тэгэхээр саваа хэдүүлээ бөглөх, шударга болгох ажил дээр онцгой энэ дээр анхаараасай гэж би хүсэж байна. Би тэгж ажиллаасай гэж бас энэ Мандхай гишүүнд бас санал тавьж байна.

Ингээд 2 дугаар зүйл гэвэл энэ салбарын хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын төлөөллийн байгууллагуудтай нь зайлшгүй уулзах ёстой шүү. Тэдний хууль ёсны, албан ёсны байр сууриудыг тусгаж байж бид ярихгүй бол гишүүд бүхнийг мэддэг юм шиг царайлж 30 жил манай улс чинь дампуурлаа шүү дээ. Гишүүд өөрсдийгөө бүүр маш ухаантай гэж үнэнээсээ итгэчхээд байгаа учраас л бид балраад байна шүү дээ. Бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг сонсоно гэдэг бол энэ үйл ажиллагааны хамгийн гол амин сүнс нь байгаасай гэж би хүсэж байна. Ингээд саналаа ажил эхлэхээс өмнө хэлж байгаа нь ингэж үр дүнтэй байлгах үүднээс бид идэвхтэй ажиллана гэдгээ дэмжиж хэлж байна.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн санал хэллээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 32 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 121 дүгээр зүйлийн 121,121.13 дахь хэсэг, 122 дугаар

зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.2 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Ерөнхий хяналтын сонсголыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойших хугацаанд төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, Засгийн газраас хариуцагдсан төлж байгаа зээлийн хүүгийн татаасны олголтын байдал, хэрэгжилт сэдвээр 2026 оны 9 дүгээр сарын 28, 29-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойших хугацаанд төрөөс олгож байгаа дэмжлэг урамшуулал, Засгийн газар газраас хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаасны олголтын байдал, хэрэгжилт сэдвээр ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг сонгосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг ханган холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Л.Өлзийсайханд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн сэдвээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт 57.9 хувиар дэмжигдлээ.

Батчимэг гишүүнийг дэмжсэнээр аваарай. Дараагийн асуудалд оръё.

16.26 цаг

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаа танилцуулна

**Б.Уянга:** Байнгын хорооны эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр тус Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулсан 3 санал 42.2.3-д заасны дагуу 1 саналыг хураах шаардлагатай гэж үзсэн болно.

Эдгээр өөрчлөлтүүдтэй холбогдуулан төслийн талаар гаргах зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн.

Ажлын хэсгийн бэлтгэсэн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийлээ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя Ц.Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Сандагаа сайд байна уу? Ирсэн байгаа юм байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ч.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Энхмөнх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны үнэлгээний газрын дарга, М.Энхмөнх хуульч, судлаач.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуухад гишүү гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Байгаль орчинд нөлөөлөх тухай

**Б.Бейсен:** Бат-Эрдэнэ гишүүний.

**М.Ганхүлэг:** Явах уу? Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн эцсийн хэлэлцүүлэг рүүгээ орж байгаа. Хоёр дахь шатын хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл авсан хэд хэдэн заалтуудын нэг нь энэ 10.5 дээрх энэ заалт дээр саналаа бас хэлээд ажлын хэсэг бас тодорхой саналыг бас хүлээж авсанд бас талархалтай байгаагаа хэлье.

Үндсэндээ энэ хуулийн өөрчлөлтөөр төслүүдээ бид бүхэн байгаль орчинд нөлөөлж байгаа байдлаар нь 3 ангилаад ингээд үндсэндээ иргэдээс санал авах байдлыг нь бас нэлээн нарийн зохицуулж өгч байгаа ийм давуу талууд бас орж байгаа.

Гэхдээ бол өмнө нь яригдаж байсан хувилбарууд дээр бол ИНХ-ын энэ бас ч эрх зүйн чадамжийг бас дордуулах, хуралдуулж болох гэсэн ийм агуулгыг бас оруулсан байсныг бол нэлээн эсэргүүцэж бас саналуудаа бас хэлсэн. Энэ удаад бол үндсэндээ хуралдуулах боломжийг нь бол нээгээд тодорхой хугацаа заасан байдалтай бол бас орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр ИНХ-ын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоног гэдэг дээр би тодруулж бас асууя. Ямар ч байсан ИНХ-аар томоохон энэ газрын тос, уран, уул уурхай, энэ цацраг идэвхт бодис тэргүүтэй энэ том төслүүдийг оруулж, хэлэлцүүлж тодорхой бас мэдээллээр хангах энэ зохицуулалтыг бас оруулж ирж байгаа нь бол сайшаалтай. Ингээд ИНХ-ыг 30 хоногийн хугацаатай бол зарлаад энэ хугацаандаа бол багтаж хуралдах ийм бас зайлшгүй шаардлага руу бол үндсэндээ орж ирж байгаа юм байна. Тэгэхээр 30 хоног дээр их, бага судалгааны түвшинд байдаг юм уу энэ дээр бас та бүхэн маань яаж тооцсон бэ?

Нөгөө талдаа ИНХ бас хуралдахгүйгээр төслүүдийг гацааж байгаа байдлыг бол бас яах вэ сайжруулах гэж байгаа энэ саналыг бол дэмжиж байгаа. Тэгэхээр энэ дундын ийм хувилбар руу орж байгаа юм байна. 30-ийг харин жоохон нэмэгдүүлэх байдаг юм уу арай бас нэг тавиу байдалтай бас тавьж өгөх байсан уу? Энэ дээр та бүхэн маань бас хариулт хэлээч ээ.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүн хариулъя.

**Б.Уянга:** Ганхүлэг гишүүнд баярлалаа. 10.5 дугаар заалт Их Хурал дээр гишүүд олон санал хэлсэн учраас тэгээд Ганхүлэг гишүүн бас яг энэ ажлын хэсэгт зарчмын зөрүүтэй саналаа өгөөд тэгээд нэлээн хэлэлцүүлгийн явцад энэ 10.5 дугаар заалт чамбайрч орж ирж байгаа. Танд талархал илэрхийлье.

Ингэсэн юм. 30 хоног гэдэг дээр бүх төслүүд болохоороо байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэж байгаа, хийгдэж байгаа. Нарийвчилсан үнэлгээгээ хийгээд таны түрүүний хэлсэн том том төслүүд газар тариалангийн том төслүүд бас га нь үнэхээр том бол бас зэрэглэл рүү орчхож байгаа. Ингээд ер нь бүх л төслүүд ийм том хэмжээний төслүүдээ хэлэлцүүлэхдээ энэ хуулийг харсан байгаа. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 16.1-д болохоороо иргэдээс аж ахуйн нэгжүүдээс төрийн байгууллагад хүсэлт, өргөдөл, гомдлыг илгээгээд хүлээдэг хугацаа нь 30 хоног байна гэдэг дээр 30 хоногийг аваад ажлын хэсэг дээр яриад хэлэлцэж орж ирсэн нь энэ байгаа юм. Нэмээд сайд хариулъя.

**Б.Бейсен:** Сандаг-Очир сайд хариулъя нэмж.

**Ц.Сандаг-Очир:** Манайх эрс тэс уур амьсгалтай орны хувьд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийх хугацаа бол их богино байдаг. Аж ахуйн нэгжүүд мэдээж зээл авч байгаа. Тийм учраас төсөл, хөтөлбөр хэрэгжих гэхээр орон нутгийн анхан шатын байгууллагууд бас иргэдийн нийтийн хурлаа хуралдуулж өгдөггүй, хэзээ хуралдах нь мэдэгдэхгүй, хурал хуралдлаа гэхэд хэлэлцэх асуудалдаа оруулж өгдөггүй гээд яг бодит байдал дээр бол асуудлууд ийм байгаа юм.

Тийм учраас нөгөө аж ахуйн нэгж компаниудад, бас төсөл гүйцэтгэгч нарт бол бас их хүндрэл бэрхшээлтэй асуудлууд одоо яг амьдрал дээр бол зөндөө асуудлууд байна. Тийм учраас бид бүхэн бас орон нутгийн анхан шатын төрийн байгууллагуудын нэгжийн удирдлагуудын үүрэг, хариуцлагыг бас нэмэгдүүлэх үүднээс одоо хугацаагүй байгаа асуудал дээр бас хугацаа тавиад иргэнээс төрийн байгууллагад гаргасан гомдлыг 30 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ гэсэн энэ хуулийн заалтын хүрээнд 30 хоногийн дотор байх нь боломж.../минут дуусав./

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Томоохон төслүүдийг ердийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр бас үндсэндээ явуулж болох ийм үндсэндээ цонхыг бас гаргах гэж байсан асуудлыг бас засчхаад бол талархалтай байна. ИНХ гэдэг бол өөрөө Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хувьд бол хамгийн чухал механизм. ИНХ-аар тодорхой тэр бүс орон нутагт нь үндсэндээ хийгдэх гэж байгаа төслүүд заавал ч үгүй орж танилцуулагдаж тодорхой саналуудыг нь бол авдаг энэ уламжлал, энэ байдал бол цаашдаа бид нар улам сайжруулаад л явах ёстой.

Орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд бол үндсэндээ бид бүхэн Дорнод аймагт 3 ч ураны үндсэндээ орд газар байж байгаа. 20 гаруй жилийн өмнөөс эхэлсэн бид нар энэ Тансагийн тал дээр байгаа энэ газрын тосны үндсэндээ энэ төсөл Монголчуудад үр өгөөжөө өгсөн, өгөөгүй, одоо буцаад энэ бас байгаль, экологидоо ямар нөлөө үзүүлж байгаа вэ гэдэг дээр байнгын л маргаантай байгаа.

Тийм учраас энэ асуудлуудыг бол заавал ч үгүй бид нар мэдээлж байх ёстой. юм.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүнд 1 минут

**М.Ганхүлэг:** ОХУ болон БНХАУ тэргүүтэй бусад улсуудтай Засгийн газар хоорондын байдаг юм уу тодорхой ийм хэлэлцээрүүдийг хийж байгаа. Ингээд нууцын зэрэглэлтэй ийм хэлэлцээрүүд болж байгаа гэдэг нэрийдлээр энэ томоохон төслүүд бас дийлэнх нь эхэлсэн байдаг. Үүнээсээ болоод Монголын талд үр өгөөжөө өгч чадахгүй байгаа олон асуудлууд бас тулгарсан байдаг. Цаашдаа ч олон хөтөлбөр юмнууд бол цаашдаа явах ёстой.

Гэхдээ иргэд энэ дээр бас өөрсдийнхөө санаа, бодлыг нээлттэй бас хэлж оролцох энэ байдлыг нь бол бид нар огтоосоо хааж болохгүй. Тэдний бас үндсэндээ санал дээр тулгуурлаж энэ төслүүд бас явах энэ механизмыг бид нар улам сайжруулж байх ёстой юм гэсэн ийм л байр суурьтай байгаа юм.

Бид нар 1, 2, 3 гэдэг ийм зэрэглэлтэй болсон. Тэгэхээр энэ 10.5 дугаар заалт маань зөвхөн энэ 1 буюу хамгийн энэ байгаль орчинд онц нөлөөтэй, сөрөг нөлөөтэй гэдэг энэ агуулга дээр зөвхөн яригдаж байна уу, эс үгүй бол бусад төслүүд дээр бас яригдаж байна уу гэдгийг тодруулж асууя.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүн хариулъя.

**Б.Уянга:** 10.5 дээр зөвхөн зэрэглэл 1 дээрх төслүүд дээр яригдаж байгаа. 10.5-ын тэр зохион байгуулалтаа хийгээд нөлөөллийн бүсийнхээ иргэд ИНХ нь хуралдангуут нь орж байгаад танилцуулаад саналаа авах энэ бүх процессыг үндэслээд 10.4 дээр засаг захиргаа, Байгаль орчны яам өөрөө зөвлөлөөрөө дамжуулаад шийдвэрээ гаргаж байгаа. Тэгэхээр Байгаль орчны яам үүнээс цааш бол дандаа зэрэглэл 1-ийн төслүүдийг хамарч үйл ажиллагаагаа явуулах ийм нөхцөл үүсэж байгаа учраас зэрэглэл 1-ийн төслүүд байгаа. Тэгээд зэрэглэл 1-д болохоор бүх төрлийн ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, газрын тосны олборлолт, газар тариалангийн төсөл, 10 мянган гагаас дээш жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалалт, 10 мянган гагаас дээш, 1мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний төсөл гэх мэт, эмийн бэлдмэлийн үйлдвэр, тамхи үйлдвэрлэл гээд томоохон үйлдвэрлэлийн төслүүд бүгдээрээ зэрэглэл 1-д орж байгаа.

**Б.Бейсен:** Далайн Батбаяр гишүүн асуулт асуухаар нэрийг нь нэмье. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Бид чинь 30 гаран жил чөлөөт зах зээл, капитализмын замаар л яваад байгаа улсууд шүү дээ. Тэгээд капитализм хүн, байгаль 2-ыг л хамгийн их дээрэлхдэг эрх ашгийг нь зөрчдөг л юм байгаа юм. Тэгээд Байгаль орчны яам нэг үе бол үндсэн чиг үүргийн яам болчихсон явж байсан. Тэгээд тэрийг нь болиулсан л даа. Би бол байгаль орчны энэ салбарын энэ улсуудыг бол байнга дэмжиж явдаг. Тэрүүгээрээ бүтээн байгуулалтыг эсэргүүцээд байгаа юм шиг нөгөөдүүл маань боддог. Юу гэж тийм юм байх вэ.

Тэгэхээр миний тодруулах гэж байгаа зүйл гэвэл би нэг юм хэлэхэд Үндсэн хуулийн 6 дугаар зүйл дээр газрын дээр байгаа, доор байгаа, газрын дээр ч, доор ч байгаа баялаг “гагцхүү” гэдэг үг байгаа шүү. “Гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хяналтад байна” гэж заасан байгаа. “Гагцхүү”. Ашгүй 10.5 дээр ингээд ороод ирлээ. Тэгээд би хууль өөрөө хөл ургаад, гар ургаад өөрөө өөрийгөө хэрэгжүүлэхгүй шүү дээ. Энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр Байгаль орчны яамнаас танин мэдүүлэх, хууль сурталчлах, өөрийгөө өмгөөлөх чадваргүй байгаа тэр хүмүүсийг мэдлэгжүүлэх ажил дээр ямар ямар арга хэмжээнүүд авдаг вэ, авах вэ? Энэ нэгэнт энэ хуулийг эцсийн шатад нь баталж байгаагийн хувьд яг хэрэгжих магадлалтай холбогдуулж би энийг асууж байна.

Дээр нь нэмээд хэлэхэд энэ чинь 2025 оны 5 сарын 16-нд бараг жил байж байж орж ирж байгаа. Одоо энэ Байгаль орчны яамны хамт олон, Төрийн нарийн, сайд бас чамбай ажил хэрэгчээр хандаж, энийг оруулж ирж байна. Дараа дараагийн байгаль орчинтой холбоотой, энэнтэй холбогдох холбогдох шүү дээ яг энэнтэй холбоотой хуулиуд нь хэдийгээр орж ирэх вэ? Энэ Байнгын хороо бол энэ дээр бол бүрэн хүчин чадлаараа дэмжиж ажиллах ёстой гэж би үзэж байна. Ингээд миний ийм 2 асуултад та бүхэн хариулаач.

**Б.Бейсен:** Ажлын хэсэг 7 номер хариулъя.

**Ш.Батбаяр:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг бас удаан хугацаанд ажилласан. Энэ хугацаандаа түншлэгч байгууллагууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллага, “Жи Ай Зэт” гээд байгууллагуудаас тодорхой дэмжлэгийг авч, иргэдэд нөлөөллийн ажлаа хийгээд явж байгаа.

Тэгээд 8 сарын 15-нд хууль хэрэгжих болон түүнээс цааш хуулийн сурталчилгааг бол хийнэ. Мөн бас яамнаас үнэлгээний байгууллагууд, мэргэжлийн холбоодтойгоо бас хамтарч ажиллаж, уулзалт арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа. Энэ холбоод маань бас энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас нэлээн бас байр суурь нэгтэй байгаа. Нэгдсэн бодолтойгоо баяртай байгаа.

Одоо яамны зүгээс нийт 14 хуулийн нэмэлт, өөрчлөлт, анхдагч болон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгын асуудал явж байгаа. Яг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын тухай хууль, Ойн тухай хууль бол тэргүүн эгнээнд явж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг бол Засгийн газраас тун удахгүй өргөн барихаар ажиллаж байна. Ер нь энэ 7 хоногт өргөн барина гэсэн бодолтой байгаа.

Тэгээд цаашдаа бол Ховордсон амьтан, ургамал, Байгалийн ургамлын тухай хууль, Генетик нөөц, түүнийг ашигласны тухай хууль, Амьтны тухай хууль гээд, Усны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ус цаг уур, хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх гээд нийт 14 хуулийн төсөл яг ид боловсруулалтын шатдаа болон өргөн барих шатдаа явж байна.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**С.Ганбаатар:** Би нэг зүйл тодруулъя. Ойлголоо, маш цэгцтэй, зөв хариулт авлаа. Ер нь энэ байгаль орчинтой холбоотой гомдол, маргааныг шийддэг механизм нь та нар дээр хэр төлөвшсөн бэ байгаа юу? Энэ ... сэтгэлмэт механизм байхгүйгээр бол тэгээд л одоо иргэний дайн шиг юм болох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ гомдлын механизм байна уу?

Хоёрдугаар асуулт гэвэл одоо баруунд чинь бол Иргэдийн Хурал дээр нэмээд ... rights гэж байна. Nature's Rights гэж байна. Энэ байгаль дэлхий өөрийнх нь эрх гэдэг юмыг шүүх дээр ярьдаг болчихсон байна. Энэ Английн шүүхүүд дээр ярьж байгаа энэ зүйлийг бол би материалыг нь өгч болно шүү. Энэ талтай холбоотой тийм хандлага, судалгаанууд манай дээр бас хийж байгаа юу? Би бусад хуулиуд, энэ хэрэгжих гэж байгаа учраас хэрэгжих шатдаа энэ хууль яригдаж байгаа учраас би энэ хууль хэрэгжихэд гомдол гарахад яах вэ гэдгийг нь асууж байгаа шүү.

**Б.Бейсен:** 7 номер хариулъя.

**Ш.Батбаяр:** Энэ удаагийн төсөлд бол нийгмийн нөлөөллийн асуудал бол шинээр орж ирж байгаа. Энэ хүрээнд гомдол барагдуулах механизм шинээр бас орж ирж байгаа. Тэгэхээр Дэлхийн банкны боловсруулсан 10 аргачлалын хүрээнд гомдлыг барагдуулах систем, тогтолцоог энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой байгаа.

Мөн манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын байгууллага бол бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, тухайн гомдол мэдээллийг хянан магадалж шийдвэрлэж байгаа.

Мөн бид бас ойрын хугацаанд энэ нөгөө Экологийн цагдаагийн албатайгаа хамтраад энэ давхар хяналтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа. Тэгэхээр цагдаагийн байгууллагын ч гэсэн оролцоог бол байгаль орчныг хамгаалах үйлсэд бол нэмэгдүүлэх чиглэлээр бид ажиллаж байгаа тодорхой түвшинд.

**Б.Бейсен:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би яамныхнаас л юм асуух гээд байгаа юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж байгаа. Ер нь бол бид нар бүтээн байгуулалт хийнэ, хийхгүй, зөв, буруу гэж ярихаас илүүтэй байгаль орчинтой харилцаж байгаа бүтээн байгуулалтуудын хувьд бол энэ үнэлгээ нь хэр юм бэ л гэдгийг харах ёстой. Тэрнээс биш хөрөнгө оруулалт нь зөв үү, буруу юу гэдэг асуудлыг бол ярих нь бол илүүц ээ гэдгийг харж байгаа юм.

Энэ үнэлгээ хийдэг субъект юм бэ гэж? Мэргэжлийн зөвлөл гэж байгаа тээ? Тэгэхээр би Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас асуух гэж байгаа нь бол ерөнхий шинжээч, шинжээчийн асуудал байгаа. Тэгээд би өөрөө бас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байх цаг хугацаанд хараат бусаар л ажиллаж ирсэн л дээ. Байгаль орчны чиглэлийн хүмүүс маань Мэргэжлийн зөвлөлийг байгуулаад ажиллахаар эдийн засагжуулах харилцаагаа тусгаж өгч чадах уу, эдийн засгийн үр нөлөөллийг тооцож чадах уу? Энэ дээр шаардлага дээр нь ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил, шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил гээд ингээд байгаль орчны чиглэлээ барьчихаж байгаа юм. Гэтэл энэ чинь 1 юм уу, 2 субъект биш. Дор хаяж 6, 7, 8, 9 гарна.

Тэгэхээр энэ дээр нэгэнт хуульчилж өгч байгаа учраас, шаардлагыг нь хуульчилж өгч байгаа учраас энэ дээр яг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам яг ямар бодолтой байгаа вэ гэдгийг би асуух гэж байгаа юм. Одоо яг энд бичсэнээр бол байгаль орчны чиглэлээр 8-аас, ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх. Шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна л гэж заасан байгаа. Тэгээд гол нь энэ нөгөө чөлөөлье гээд байдаг, аж ахуйн нэгжүүддээ боломжийг нь олгоё гээд байдаг. Гэхдээ стандарт шаардлага бид нар тавьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг мэргэжлийн яам маань ямар саналтай байгаа вэ гэдгийг би асуух гэж байна.

Одоогийн өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа хуулийн дагуу Ерөнхий шинжээч нь өөрөө ажиллаж байгаа процесс алдаа, сул тал юу байна? Хуульд өөрчлөлт орсноор ямар давуу тал, ямар сул тал үүсэх вэ гэдгийг ажиллаад явж байгаа, газар дээр нь ажиллаад явж байгаа мэргэжлийн хүмүүс хариулаасай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Б.Бейсен:** Яамны ажлын хэсгээс 8 номер хариулъя.

**Г.Энхмөнх:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүрээлэн буй орчны бодлогын газрын дарга Энхмөнх. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Шинжээч, ерөнхий шинжээчтэй холбоотой шалгуур, шаардлагуудыг тавьж өгсөн. Энэ дээр ерөнхий шинжээчийн хувьд бол Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр бол ерөнхий шинжээчийг байгаль орчны чиглэлээр ажилласан 8-аас доошгүй жил ажилласан гэдэг шаардлагыг тавьж оруулж ирсэн. Ингэснээрээ бид энэ дээр бол судалгаа хийж үзсэн. Жилд байгаль орчны чиглэлээр төгсөж байгаа улсын 7 сургууль дээр бол 200-аас 250 оюутан, мэргэжилтэн бол бэлтгэгдэж гардаг юм байна лээ. Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн дүн шинжилгээгээр байгаль орчны чиглэлээр төгссөн нийт ажилчдын 83 хувь нь бол энэ салбартаа ажиллаж байна гэсэн ийм судалгаа байгаа.

Ингээд харахад одоо яг 8 жилээс дээш ажилласан мэргэжилтэй боловсон хүчин, шинжээч, судлаачдыг аваад үзэхэд бол 3 мянга гаран хүн бол энэ албан тушаал дээр нь ажиллах боломж, бололцоо байна. гэдэг зүйл харагдаж байгаа.

Нөгөө талаасаа шинжээчийн хувьд бол 3 жилийн шаардлагыг тавьж өгч байгаа. 3 жилийн шаардлагыг хангаад орж ирж байгаа шинжээчдийн хувьд бол энэ мөн энэ боловсон хүчин, нөөцийн бүрэн хангалттай байна гэдэг зүйл харагдаж

байгаа. Нөгөө талаасаа төрийн албаны хуультай уяж холбогдуулах асуудал нь бол албан тушаалын тодорхойлолт дээр үндсэн чиг үүргийг нь зааж өгч байгаа. Үүгээр бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой зохицуулалт, хяналт, цаашлаад энэ ерөнхий шинжээчийн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой энэ асуудлууд байгаа. Гагцхүү гишүүний хэлсэн тэр эдийн засагтай холбоотой асуудлаар одоогийн байгаа Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Эдийн засаг, хөгжлийн яам болоод эдийн засаг нийгэмтэй холбоотой хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийг бол оролцуулаад ингээд явах бүрэн боломжтой гэж харж байгаа.

**Б.Бейсен:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Үгүй. яах вэ ажлын хэсэг байгуулаад оролцоод явлаа ч гэсэн төрийг мэргэжлийн зөвлөл авч хэлэлцэхдээ ерөнхий шинжээч, шинжээч нарын дүгнэлтээр л гарч байгаа шүү дээ. Гол асуудал тэр байхгүй юу. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам байна уу, Сангийн яам байна уу, орон тооны бус хэлбэрээр тодорхой хэмжээнд бусад ТББ болон мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авчихсан байна уу тэрийг байгаль хамгааллын чиглэл дээр ажиллаж байгаа Мэргэжлийн зөвлөл хэр хэмжээтэй хүлээж авч чадах чадамж байгаа вэ л гэдэг асуудлыг л хөндөж байгаа юм. Хэрвээ шинжээч дотор эдийн засгийн суурь мэдлэгтэй хүн байвал ядаж тухайн ирсэн саналыг хүлээж авах нь, тайлбарлах нь илүү дээр байхгүй юу. Би яагаад энийг хэлээд байна гэхээр байгаль хамгааллын чиглэлд ажиллаж байгаа албан хаагчид маань бол нэг номерт байгаль хамгааллаа л барьдаг. Зарчим нь зөв.

Гэхдээ эдийн засагч бол харилцаан дээр алдаа гараад Мэргэжлийн зөвлөлөөс гарсан шийдвэрүүд.../минут дуусав./

**Б.Бейсен:** 8 номер. Хэдэн номер хариулах уу? 8 номер хариулъя.

**Г.Энхмөнх:** Энэ дээр гишүүн ээ ийм байгаа юм. Аливаа төслүүдийн хувьд бол ТЭЗҮ буюу эдийн засгийн тооцоог нь хийгээд оруулж ирж байгаа. Энэ дээр үндэслээд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнүүд хийгдээд явж байгаа. Гэхдээ таны саналыг бид цаашдын ажлын зохион байгуулалт болоод албан тушаалын тодорхойлолтууд дээрээ анхаарч үзье. Зайлшгүй шаардлага бол таны хэлж байгаагаар эдийн засаг болоод энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэдэг зүйл оруулж ирж байгаа учраас энэ зүйлийг бол орхигдуулж болохгүй гэдэг саналыг бол хүлээж авч байна, дэмжиж байна.

Тэгээд цаашдаа бид энэ албан тушаалын тодорхойлолт дээр бол энэ байгаль орчны чиглэлээр эдийн засагтай холбоотой, ногоон хөгжилтэй холбоотой мөн энэ социал импакт буюу энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудлыг бол тусгаад ингээд бас оруулаад явуулах боломжтой. Гол нь зүгээр энэ дээр суурь нь байгаль орчны чиглэлээр ажилласан мэргэжилтэн гэдэг энэ.../минут дуусав./

**Б.Бейсен:** Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

**Д.Батбаяр:** Ажлын хэсгийнх нь энэ өдрийн мэнд хүргэе. Сая энэ нэмэлтээр орж ирсэн Нөлөөлөх байдлын тухай хуулийн оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дээр бас асууж тодруулах зүйл байсан. Тэгээд ажлын хэсгийн ахлагч болон салбарын сайдтай ярилцаад сая тодорхой мэдээлэл авчихлаа.

**Б.Бейсен:** Сэддорж гишүүн асуулт асуух юм байна. Сэддорж гишүүний микрофоныг өгье.

**Р.Сэддорж:** Байгалийн нөөц баялгийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй төслүүдийн байгаль орчныг хамгаалах баталгаа болдог зүйл бол тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, дүгнэх харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-д бол заасан журмаар зохицуулж байдаг. Тухайн жилд хийсэн байгаль орчныг хамгаалах энэ нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгааллын талаар хийсэн ажлаа орон нутгийн комисстоо хүлээлгэн өгөөд нөхөн сэргээлтийн мөнгөн хөрөнгийн баталгаа Төрийн сангийн тусгай дансанд байршуулж, дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж байгаа нь ялангуяа уул уурхайн нөлөөлөлд байгаа, том төслүүд хэрэгжиж байгаа иргэдийн нийгэм, эрүүл мэндийг хамгаалахад бол чухал баталгаа болж өгдөг. Тэгээд энэ 9.4-д заасан энэ журмыг энэ хэвээр нь байлгана биз дээ гэсэн асуулт байна. Одоо байгаагаар н.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүн хариулъя.

**Б.Уянга:** 9.4 гэдэг журам дээр нэг зүйл орж ирж байгаа. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаад нарийвчилсан үнэлгээ хийгдэх тохиолдолд нарийвчилсан үнэлгээндээ байгаа менежментийн төлөвлөгөөгөө дагаад үйл ажиллагаа явуулъя. Менежментийн төлөвлөгөөнд нь өөрчлөлт орвол тухайн жилээ мэдэгдэх байдлаар ингээд ажлын хэсэг дээр бол нэлээн яригдсан. Тэгэхээр бол журам бол хэвээрээ. Та уул уурхайн салбарыг хөндсөн учраас хайгуул, ашиглалтаар нь ангилаад хариулбал хайгуулын үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрлийнхөн бол яг таны хэлдгээр менежментийн төлөвлөгөөгөө батлуулаад байгаль орчныхоо 50 хувийн барьцаагаа байршуулаад ингээд явна.

Харин нарийвчилсан үнэлгээ хийгдсэн газрууд бол тухайн нарийвчилсан үнэлгээндээ 5 жилээр хийчихсэн байгаа менежментийнхээ төлөвлөгөөний дагуу жил жилийнхээ барьцааг байршуулаад ингээд явахаар нарийвчилсан үнэлгээ батлагдсан бол ингээ гээд жаахан тийм аж ахуйн нэгжүүдийг чөлөөлөх байдлаар ажлын хэсэг дээр ярилцаж байгаад 9.4-ийн журмын агуулга арай өөрчлөгдсөн. Тэр нь бол зөвхөн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн төслүүд дээр дахин тэр дотор нь угаасаа орчихсон байдаг 5 жилийн төлөвлөгөөгөө тус тусад нь дахин нэг баримт бичиг болгон батлуулахгүйгээр нэг таван жилээр батлуулсныгаа дагаад явчихна. Гэхдээ барьцаа эд нар бол 50 хувиараа байршуулагддагаараа байршуулагдаад явна.

Тэгээд ер нь уул уурхайн салбартай холбоотой яг энэ менежментийн төлөвлөгөөний агуулга нь бол Ашигт малтмалын тухай хуулиараа явчхаж байгаа. Яг энэ нөлөөллийн үнэлгээ дээр бол холбогдох журам нь батлагдахдаа нарийвчилсан үнэлгээ хийгдсэн төслүүддээ арай хөнгөвчлөгдөж бичиг баримтын давхардал эд нар нь бол багасаж байгаа ийм байдлаар журам нь боловсруулагдахаар байгаа.

**Б.Бейсен:** Сэддорж гишүүн тодруулъя.

**Р.Сэддорж:** Би энэ протоколд тэмдэглүүлье. Энэ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-д заасан журмыг эрх бүхий яам нь маш сайн боловсруулж, санал авч, танилцуулж ажиллахыг хүсэж байна.

**Б.Бейсен:** Сэддорж гишүүний саналыг протоколд тусгая. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу хураалгахаар бэлдсэн 4 саналын хураалт явуулна.

Эхлээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 3 саналаар санал хураана. Гишүүдэд энэ юуг танилцуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх.”. Санал хураалт. Санал хураалтад бэлдээрэй. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт.

Санал хураалт 68.4 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.”. Санал хураалт.

Санал 68.4 хувиар дэмжигдлээ.

3 дахь санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны Иргэдийн Нийтийн хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хонгийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.”. Санал хураалт.

Ажлын хэсгийн санал 68.4 хувиар дэмжигдлээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасны дагуу 1 санал хураана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ажлын хэсгийн санал 68.4 хувиар дэмжигдлээ.

Санал уншиж танилцуулна. Энэ саналаар дахин санал хураалгах дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт түрүүний түрүүний заалтаар.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргая.

**Б.Бат-Эрдэнэ:** Саяын сүүлийн 2 саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

**Б.Бейсен:** Бат-Өлзий гишүүний горимын саналын дагуу. Тийм үү? Далайн Батбаяр. Батбаяр гишүүн горимын санал гаргах юм байна.

**Д.Батбаяр:** Сая маш чухал санал хураалт явж байсан. Тэгээд энд төхөөрөмж яг тэр үед гацчихлаа. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож, 2 санал хураалтыг хүчингүй болгох энэ горимын санал гаргаж байна. Санал хурааж өгнө үү. Тэгээд дахиж шинээр санал хураалгамаар хүсэлтэй байна.

**Б.Бейсен:** Далайн Батбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу түрүүчийн 2 санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүн дэмжиж, санал 68.4 хувиар дэмжигдлээ.

Түрүүн саналаа уншиж танилцуулсан байгаа. Энэ саналаар дахин санал хураалгахыг дэмжье гэдэг саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 68.4 хувиар дэмжигдлээ.

Одоо үндсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт санал.

Үндсэн саналаар санал хураасан санал хураалт маань 68.4 хувиар дэмжигдлээ. Санал хураалт хурааж дууслаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх танилцуулгыг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулна.

Дараагийн асуудалд оръё. Ажлын хэсгээ оруулаарай. Дараагийн асуудалд оръё.

17.03 цаг

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028, 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэж заасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сайд нараа оруулъя. Энхбаяр сайд яасан бол? Ажлын хэсгийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Ц.Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ц.Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байна уу? Эдийн засгийн хөгжлийн яамнаас С.Даваасүрэн Эдийн засгийн хөгжлийн дэд сайд, Л.Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Мөнгөнсүх Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Д.Эрдэнэтуяа Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, О.Мягмардорж Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга байна уу? Ирсэн байна юм уу? З.Райымбек Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, П.Чандмань Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Сангийн яамнаас Б.Анар Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Тулгаа Санхүүгийн бодлогын газрын дарга. Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ч.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Н.Цогтбаяр Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Д.Дэчин Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Болорсүх Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Хуулийн 1 дүгээр зүйлтэй. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрс өгнө үү.

Ганхүлэг гишүүнээр. Асуулт нэрээ өг. Төсвийн хүрээний мэдэгдэл. Нэг л асуудал байгаа шүү дээ. Асуух юм уу Замира гишүүн? Замира гишүүнээр тасалъя. Ганхүлэг гишүүний асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Өдрийн мэнд хүргэе. Чуулган дээр асуусан асуултаа би илүү дахиад нарийвчлаад бас асуучихъя гэж бодож байна. Тогтвортой хөдөө аж ахуйн тухай асуудлыг бас хөндөөд байгаа. Энэ хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзэлж байгаа хувь, хэмжээ тухайн жилийн зудын болон нөхцөл байдлаас хамаарч ингээд маш өндөр хэлбэлзэлтэй байгаад байгаа. Сүүлийн 5 жилээр ингээд авахад бол үндсэндээ -5.5 руугаа хүртэл унаад ингээд сүүлийн жилүүдэд бараг 20, 30 хувь руугаа бол өсөж орж ирж байгаа юм. Тэгээд ойролцоогоор ДНБ-д эзлэх хувь, хэмжээ бол хөдөө аж ахуйн салбарын хувьд бол 10 орчим хувь руу үндсэндээ бол орж ирж байна.

Тэгэхээр ирэх 27 он, 28 он, 29 онд ер нь бид яг энэ хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой байна гэж үзээд байна уу, эс үгүй бол үндсэндээ энэ хэлбэлзлийг үндсэндээ яаж нарийн тооцдог юм бэ? Тэр нь цаашдаа үндсэндээ энэ салбарын эдийн засагт үзүүлэх энэ нөлөөллийг тогтвортой байлгах тал дээр бас ямаршуу бас саналуудтай байна вэ гэсэн ийм агуулгыг үндсэндээ асуугаад юу байгаа юм л даа.

Тэгэхээр яах вэ олон улсын байгууллагууд бас янз янзын байдлаар бид бүхэнд бол үндсэндээ зөвлөгөөнүүдийг бас өгөөд байгаа. Энэ салбарын оруулж байгаа хөрөнгө оруулалтууд бол үндсэндээ энэ тогтвортой хөдөө аж ахуй руу чиглэсэн бие даасан энэ мал аж ахуй, газар тариалангийн салбарыг бий болгох руу үндсэндээ зорьсон ийм салбар байх ёстой гэдэг байдлыг бол зөвлөөд байгаа юм.

Тэгэхээр энэ ДНБ-д үндсэндээ үзүүлж байгаа энэ салбарын хувь, хэмжээгээ өсгөх гэхээсээ илүүтэй байгаа байдлыг нь тэнцвэртэй авч явах гэдэг асуудал бол бидний хувьд бол том сорилт бас болж байна. Тэгэхээр энэ дээр яаж ер нь тооцдог юм, зудын эрсдэлийг бас яаж нарийвчилж тооцдог юм? Тэр үндсэндээ тооцооллыг нарийн би асуусанд бас хариултаа бас бүрэн авч чадаагүй. Энийг дахиад тодруулъя.

**Б.Бейсен:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл бол манай тэргүүлэх гол чиглэл. Сүүлийн жилүүдэд үзүүлсэн эдийн засгийн өсөлт бол энэ салбарт чиглэсэн бодлогын тогтвортой арга хэмжээний үр дүнд Атарын 4 дүгээр аян, Хүнсний хувьсгалт, Цагаан алт хөтөлбөрийн үр дүнд салбар дахь ажлын байр нэмэгдсэн.

Тухайлбал, 38 мянган ажлын байр шинээр бий болоод аж ахуйн нэгжүүдийн эрчимжилт эрс ахиц гарсан. Өмнө нь бол хөдөө аж ахуйн салбар өвөлжилтийн байдал, төл авалт, ган, зудын эрсдэлтэй холбоотой савлагаатай байсан бол харьцангуй тогтворжино. Нэг талдаа мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг нэлээн урамшуулсан бодлогууд явсан. Үүнтэй холбоотойгоор гол төллөх малаа авч үлдээд бусад малыг бол эдийн засгийн эргэлтэд оруулдаг.

Нөгөө талдаа Атарын 4 дүгээр аяны хүрээнд 200 мянган га талбай газар тариаланд эргэлт нь шинээр нэмэгдэж байгаа. Энэ маань өөрөө тэжээлийн бааз, тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлж байгаа. Тэжээлийн аж ахуйнууд тэжээлийн үйлдвэрүүд ихээр бий болж байна.

Нөгөө талдаа уламжлалт мал аж ахуйгаа эрсдэлээс хамгаалахад энд таримал тэжээл их чухал гэдгийг бол хаа хаанаа ойлгож, малчид бол тэр тэжээл тарих сонирхолтой болсон. Энийгээ дагаад сүүлийн жилүүдэд анзаарсан бол том малын зүй бус хорогдол эрс багасаад өмнө нь сая саяараа хорогддог бол одоо тийм тоогүй болж байна. Үндсэндээ намар бүгдийг нь эргэлтэд хэрэгцээлээд эргэлтэд эдийн засгийн эргэлтэд оруулж чадаж байна. Яг төллөх малаа аваад, сайн тэжээгээд онд оруулаад, төлөө бүтэн авчаж байгаа ийм хандлага, их сайн хандлага руу явж байгаа болохоор одоо байгалиас хамааралтай энэ хамаарал нь эрс багасна.

Цаашдаа энэ нь өөрөө энэ дээр мал аж ахуй дээр суурилсан, газар тариалан дээр суурилсан энэ тогтвортой хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийг тогтвортой байхад энэ маань өөрөө шууд нөлөөлж эхэлнэ.

Нөгөө талаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг дэмжих томоохон бодлого арга хэмжээ явж байгаа. Энэ та мэдэж байгаа Евроази эдийн засагтай холбоотой гэрээ 7 сарын эхний 2 дахь 7 хоног гэхэд хэрэгжиж эхэлнэ. Энэ хүрээнд манай хөдөө аж ахуйн гаралтай 360 гаруй нэр төрлийн бараа экспортлох боломж бүрдэж байгаа. Энэ бол бас нэлээн бас салбарын хөгжлийг тогтвортой байдал хангахад их чухал үүрэг гүйцэтгэнэ.

Бидний гол зорилт бол уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийг олон тулгуурт болгох. Тэр бодлогыг нь тэргүүлэх чиглэлийн нь хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл. Мөн аялал жуулчлал, үйлчилгээний салбарыг бол онцгой анхаарч байгаа. Тэгээд энэ бодлогын хүрээнд бол хөдөө аж ахуйн салбарын бол тогтвортой байх энэ зорилт бол хангагдаж эхэлнэ л гэж хэлэхийг хүсэж байна.

Болорчулуун дарга нэмээд салбарын бодлогуудаа нэмээд хэлчих.

**Б.Бейсен:** Болорчулуун дарга нэмж хариулъя. 9 номерын микрофон.

**Ц.Болорчулуун:** Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Ганхүлэг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Тэгэхээр сая Энхбаяр сайдын хэлсэн дээр нэмээд хэлэхэд бол ер нь Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын бичиг баримтууд энэ тогтвортой хөдөө аж ахуйг бий болгоно гэж том зорилтыг бол дэвшүүлсэн. Энэ хүрээндээ бид энд дунд хугацааны бодлогын бичиг баримтуудтай энэ ажлуудаа бас салбарлаад тусгаад хэрэгжүүлээд явж байгаа. Дээрээс нь нэмж хэлэхэд бол энэ малын эрүүл мэнд, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт гэдэг бол хамгийн чухал асуудал байгаа. Тэгэхээр бид нар бол энэ малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлд бас онцгой анхаарч байж бид нар энэ тогтвортой хөдөө аж ахуйг бий болгох энэ чиглэлийг бас авч явуулах ийм чиглэл байгаа.

Тийм учраас бид нар малын халдварт болон гоц халдварт өвчнөөс монгол малыг эрүүл байлгах энэ хүрээндээ бид нар Био комбинатыг бүрэн шинэчилж, дотоодын вакцин үйлдвэрлэлээ нэмэгдүүлж.../минут дуусав./

**Б.Бейсен:** 9 номер гүйцээж хариулъя.

**Ц.Болорчулуун:** Би комбинатыг бүрэн шинэчилснээр дотооддоо вакцин үйлдвэрлэлээ явуулж түүнчлэн монгол малыг эрүүл байлгаж байж бид нар энэ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг, махны экспортыг нэмэгдүүлэх ийм боломж үүснэ.

Нөгөө талдаа бол мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс гарч байгаа түүхий эд бүтээгдэхүүн болгоныг үнэ цэнтэй байлгах үүднээс арьс, ширний үйлдвэрүүд тухайлах юм бол баруун бүсэд Ховдын үйлдвэр, технологийн паркийг ашиглалтад оруулж, дээрээс нь энэ Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийг ашиглалтад оруулснаар бол малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх энэ ажлуудыг бас зохион байгуулснаар энэ зорилтыг бас тодорхой хэмжээнд хангахад нөлөөлнө гэж үзэж байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Нарийн яг тодорхой хариулт авч чадахгүй л байгаа юм шинжлэх ухаан. Ер нь ирэх 3 жилд ер нь зуд болох болохгүй гэдгийг тооцоолох боломжууд бас байгаа байх. Өмнөх үндсэндээ олон жилийн дата, мэдээллүүдийг үндсэндээ судалж байгаад тэгээд энийгээ бид нар урьдчилан мэддэг хариу арга хэмжээ авах тактик юмнуудаа боловсруулдаг энэ үндсэндээ энэ ирэх ирэх жилүүдийн төсөөллүүд дээрээ энийгээ бас тогтвортой яг ямар байдлаар нь байдаг юм ингээд тусгаад явах ийм агуулгыг асуухаар яг нөгөө хөтөлбөр, бусад хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээ л ингээд яриад байна л даа.

Ер нь бид нар энэ цаг уурын нөхцөл байдлыг бол хязгаарлаж зохион байгуулахад хэцүү шүү дээ. Тэгээд хариу арга хэмжээ, яаж дасан зохицох вэ гэдэг тухай л үндсэндээ ярих ёстой. Сүүлийн жилүүдэд бол үндсэндээ энэ байгалийн энэ гамшигт үзэгдлүүдийн тоо улам ойртож байна. 5, 10 жилээр үндсэндээ хэмжигдэж байна. Тэгээд энийгээ нарийн тооцоолж чадахгүй байна, бид нар таамаглаж чадахгүй байна. Энийг яаж тооцоолж байна вэ гэдэг тухай л би асуугаад байгаа байхгүй юу.../минут дуусав./

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүнд 1 минут.

**М.Ганхүлэг:** Тэгж байж бидний энэ гаргаж байгаа энэ төсөөллийн тоо, утга юмнууд бол нарийн гарна. Бид нар ДНБ-ий 10 орчим хувийг хэт тогтвортой байх уу үгүй юү гэдэг тухай яриад байгаа, бусад салбарууд нь нөхөх үү яах вэ гэдэг тухай биш. Тэгэхээр энийгээ хадгалах чиглэлийн ийм нарийн тооцоолол юмнууд дээрээ ажлын хэсэг нь яаж ажилладаг юм, олон улсын ийм судалгаа юмнууд дээрээ бас үндэслэж юмнууд гаргадаг юм уу гэдэг ийм тооцооллын тухай би асуугаад байгаа юм.

Хариу арга хэмжээтэй холбогдолтой асуудлыг би дараагийн хэлэлцүүлэг дээр би бол үндсэндээ бас ярина. Энэ малчдыг зудын эрсдэлээс хамгаалах “1000:100” гэдэг хөтөлбөрийг бүүр 2 гараа өргөөд дэмжих хэрэгтэй. Болорчулуун дарга энэ тухай мэдээллийг та бүүр сайхан дэлгэрүүлээд өгөх хэрэгтэй. Энэ бол

бидний үндсэндээ авч болох арга хэмжээнүүд байгаа. Хэдхэн жилийн өмнөх л бид нар зудаар 8, 9 саяар нь нэг дор бид нар малаа алдсан шүү дээ. Тэгээд энэ мал үндсэндээ хэн нэгний мал үхээд байгаа биш Монголын эдийн засагт оруулах ёстой байсан хөрөнгө оруулалт тэр чигтээ унаад байгаа ийм л асуудал. Тэгэхээр энийг яаж тооцоолдог болох юм бэ? Энийгээ яаж.../минут дуусав./

**Б.Бейсен:** 5 номер Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Монгол орны жилийн дундаж агаарын температур сүүлийн 35 жил, 85 жилийн хугацаанд 2.5C хэмээр дулаараад байгаа. Сүүлийн 60 жилийн дата байгаа. Ган, зудын давтамж. Эндээс дүгнэлт хийгээд юу харагдаж байгаа вэ гэвэл цаашдаа байгалийн энэ эрсдэл, ган, зудын давтамж ойртож байгаа, нэмэгдэж байгаа хохирол, цар хүрээ нэмэгдэж байгаа. Энийг даван туулах гол бодлого бол нөгөө үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх. Тэр хүрээнд бид нар энэ уламжлалт мал аж ахуйгаа энэ байгаль цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, даван гарах, яаж өөрчлөх вэ гэж.

Нэгдүгээрт, тэжээл түрүүн ярьдаг тэжээл, тэжээлийн таримал, тэжээл, ургамлын тариалах талбайгаа нэмэгдүүлэх, тэгээд ялангуяа малын хашаа, саравч, худаг, ус, бэлчээр ашиглалтын асуудлууд гээд олон зүйл.

Нөгөө талаасаа экспорт, зах зээлээ гаргаж өгөх, экспортод хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн чинь идэвхтэй арилжсанаар нөгөө талдаа нөгөө мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа улсуудын маань орлого баталгаажиж байна. Орлогоо дагаад өөртөө хөрөнгө оруулалт хийх чадавх нь дээшилж байна. Энэ нь өөрөө энэ хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой болгох, дээрээс нь энэ хөнгөн, хүнсний үйлдвэрээ түүхий эдээр хангах гол суурь болж байгаа. Тэгэхээр энэ цаг агаарын аюултай гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх энэ мэдээллийн систем энэ чиглэлийн хөрөнгө оруулалт бол Монгол Улсын хэмжээнд бол нэлээн өндөр түвшинд хангалттай. Зарлан мэдээлэх, түгээх, ... тэмцэх, авран хамгаалах гээд олон арга хэмжээнүүд бол төлөвлөгдөөд, төсөвлөгдөөд бодлогын арга хэмжээнүүд бол авагдаад л явж байгаа.

**Б.Бейсен:** 9 номер Болорчулуун дарга хариулъя. Нэмж хариулъя.

**Ц.Болорчулуун:** Тэгэхээр ер нь бол бид нар энэ эрсдэлийг даван туулахад олон арга хэмжээ байгаагаас хамгийн түрүүн энэ тэжээл тариалалт дээр онцгой анхаарч энэ жилийн тухайд гэх юм бол 17 аймгийн 23 сумд яг 1 сумын 1 багт 100 га-гаар ихэссэн нутагтаа эзэн “1000:100” гэсэн ийм төслийг бол хэрэгжүүлж эхэлж байгаа. Ингэж таримал тэжээлийн ашиг тус, үнэ цэнийг мэдрүүлж, малчдад ойлгуулж энийг улмаар улсын хэмжээнд 1000 багт 100 га-гаар энэ тэжээл тариалалтыг өргөжүүлж явах энэ төслийг эхлүүлж байгаа. Энэ төслийг бол энэ жилийн тухайд амжилттай эхлүүлснээр энэ цаашдаа бид нар энэ эрсдэлийг даван туулах, сөрөн тэсвэрлэх энэ боломжийг тодорхой хэмжээнд бүрдүүлнэ гэж харж байгаа. Тийм учраас энэ төслөө бас ингээд эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад явж байна гэдгийг хэлье.

**Б.Бейсен:** Мандхай гишүүний нэрийг нэмье асуулт асуухаар. Замира гишүүн асуулт асууя.

**С.Замира:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ өргөн мэдүүлж байгаа төсөл нь Монгол орны эдийн засаг нь хэвийн байж, ард олон нь

ажил албатай байж, айл бүрийн орлого нэмэгдэж байж тэгж байж биеллээ олох болов уу гээд би бодож байна. Тийм учраас хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, бизнесменүүд ч гэсэн энэ ямар нэг үйл ажиллагаа явуулахын төлөө бага хүүтэй зээл байх ёстой Монгол оронд. Банкнуудын зээл маш өндөр хүүтэй, бас хугацаа нь богино. Одоогийн Ерөнхий сайд ч ярьж байсан та нар бүгдээрээ ярьсан гадаадын банк оруулж ирэх асуудал нь юу болж байгаа юм бол доо? Ийм бага хүүтэй банкнууд бий болж байж Монгол орон бизнесменүүдийн үйл ажиллагаа нь дэмжигдэж байж тэгж хөгжиж, улс орон үйлдвэрүүд хөгжинэ гэж бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, шатахууны үйлдвэр барьж байгаа биз дээ? Түрүүн юун дээр гадаадаас мөнгөө оруулж ирнэ гээд яасан нь батлагдаагүй. Тэгэхдээ тэр шатахууны үйлдвэр нь бол түүхий эд нь байж байж баригдана биз дээ? Одоо өөрсдийн үйлдвэр байж байж яагаад түүхий эдийг нь экспортолж байгаа юм бол? Энэ дээр хариу өгөх юм байна уу?

Гуравдугаарт, энэ аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Тэрнээс эдийн засгийн бас нэг хэсэг эх үүсвэрийг нь олно гээд яриад байгаа. Ялангуяа баруун бүс, Баян-Өлгий аймаг бол аялал жуулчлалын бүс гээд зарласан байсан. Тэгээд тэрэнтэй холбоотой Азийн орнуудаар холбоо тогтоохын төлөө Казакстан-Монгол, Астана-Улаанбаатар гэсэн "SCAT" гэдэг компанийн онгоц нисгэхээр өчигдөр 6 сараас эхлэн хийхээр нээлтийг нь хийлээ. Тэгэхдээ энэ чинь Астана-Улаанбаатар гэсэн чиглэл дунд бас Баян-Өлгий гэсэн яг аялал жуулчлалын бүс дээр бас буух ёстой байсан. Энэ дээр, энэ юман дээр Дэлгэрсайхан сайдын ярьж байгаагаар тендер нь зарлагдаад тендер будилаантай болсон учраас зогсонги байдалд орчихсон гээд яриад байсан. Энэ нь хэзээ шийдэгдэх вэ?

Дөрөвдүгээрт, гол юм нь өрх бүрийн орлого, жижиг, дунд бизнесменүүдийн үйл ажиллагаа. Энэ тал дээр ер нь төлөвлөж байгаа юм байна уу, яаж сэргээх гээд байна? Уг нь өрх бүрийн орлого нь нэмэгдэж, дундад шатын бизнесменүүдийн хөл дээр нь босож байж энэ Монгол орны эдийн засаг нь ахиц гарах ёстой шүү дээ. Бүгдээрээ хувааж төслийг ингээд энэ төслийн тухайлаад тэрийг хэрэгжүүлэхийн төлөө яриад байдаг. Энийг яаж бүрдүүлэх вэ гэдэг тал дээр, яаж энэ.../минут дуусав./

**Б.Бейсен:** Замира гишүүнд 1 минут.

**С.Замира:** Одоогийн тогтворгүй байгаа энэ эдийн засаг яаж тогтвортой болох вэ энэ гэдэг тал дээр ер нь нэг ч санаачилга байхгүй. Байсан ч тэгээд яриа, зүгээр ярианы шатдаа үр дүн байхгүй. Энэ бүгдийг нь эцэслэх цаг нь болсон гэж би бодож байна. Дахиад үргэлжлээд энэ байдалдаа 30 хэдэн жил явах юм бол мэдэхгүй юу болох юм бүү мэд. Тэгэхдээ та нар, та бүхнийг ажил хийхгүй байна гэж хэлэхгүй байна. Би ажил хийж байгаа. Тэгэхдээ үр дүн нь багатай байна. Үр дүнг гаргах л хэрэгтэй. Хэрвээ хэлсэн бол ажил хэрэг болох ёстой. Банк оруулна гэвэл оруулах ёстой. Чадах ... үйлдвэр барина гэвэл барих ёстой. Түүхий эдийг нь хамгаалах ёстой. Жижиг, дунд бизнесийг дэмжинэ. Өрх бүрийн орлогыг нэмэгдүүлнэ гэсэн бол тэрийг нэмэгдүүлэх ёстой. Тэгж байж багш, эмч нарын цалин нэмэгдэнэ, тэтгэвэр тэд нэмэгдэнэ. Энэ бол тодорхой. Энэ бүхэн хэзээ шийдэгдэх вэ?

**Б.Бейсен:** Энхбаяр сайд хариулах уу ? 5 номер.

**Ж.Энхбаяр:** Шууд нислэгтэй холбоотой Баян-Өлгий, Скумент, Астана-Улаанбаатар, Алмата-Улаанбаатар гэсэн шууд нислэгүүдийг нисгэхээр холбогдох гэрээнүүд хийгдсэн. Ингээд рейсүүд аяллаа эхэлж байх шиг байна. Ингээд энэ аж ахуйн нэгжүүд бид нар бол 2 улсын сая гэрээ хийж боломжийг нь хангасан. Тэгээд аж ахуйн нэгжүүд бол өөрсдийн орлого, ашгаа тооцоод өнөөдрийн байдлаар энэ 3 шууд нислэг бол явах ийм маршрут тохиоод явж байна.

Жижиг, дунд эрхлэгчтэй холбоотой зээлийн эх үүсвэр муу байгаа. Тэгэхдээ яах вэ чамлахаар чанга атга гэж сүүлийн 5 жил үндсэндээ 6 жил жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр улсын төсөв дээр тавигдаагүй. Тэгээд эргэн төлөлтийнхөө мөнгөөр л бага хэмжээнд хуваарилалтаа хийгээд л явж ирсэн. Тэр бодлого нь үндсэндээ үргэлжлээд л ингээд цаашдаа явна.

Мөн ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд Нийгмийн хамгааллын яаман дээр байгаа тодорхой эх үүсвэр байгаа. Энэ нь болохоор яг зорилтот бүлгийн дэмжих бизнес эрхлэхэд зориулсан ийм бичил зээлийг дэмжсэн ийм бас сан байгаа. Одоо энэ 2 хүрээнд л манай энэ жижиг, дунд үйлдвэрлэл бичил зээлийг дэмжиж байгаа ийм боломж байна.

Зээлийн эх үүсвэр хямд болоход бол мэдээж гадаад банкны хөрөнгө оруулалттай банкны үүрэг их өндөр гэж үзэж энэ зах зээл дээр нэлээн либералчлах, урих, нээлттэй хөрөнгө оруулах, үйл ажиллагаа явуулахыг урьж байгаа боловч яг өнөөдрийн байдлаар Монголд салбараа нээгээд үйл ажиллагаагаа нээсэн, нээе гэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай банк бол алга байна. Энэ дээр бас бид нар томоохон хуулийн өөрчлөлт их саад болж байгаа. Энэ банкнуудын хувьцааны хувийг 5 билүү, 2 билүү банкны хувьцаа? 20 хувиас илүүгүй эзэмших асуудлаар босго их нэлээн нам тогтчихсон. Иймд стратегийн банкны хувьцаа аваад хөрөнгө оруулаад ороод ирэх тийм итгэл нэлээн төрөхгүй, хяналтын багцаа авч чадахгүй байгаа болохоор бас энэ нь өөрөө хуулиар бид нар хөрөнгө оруулалтыг өөрсдөө хязгаарлачихсан ийм зүйл байгаа.

Тэгэхээр энэ хуулийг бол өөрчлөх ийм зайлшгүй шаардлага бас гарч байгаа. Шатахуунтай холбоотой нөөцийн арга хэмжээнүүдийг авч байна. Нөөцийн савнуудыг хөрөнгө оруулалтаар барьж байна. Яагаад экспортолж байна гэдэгтэй холбоотойгоор бид зүүн бүсэд тодорхой хэмжээний нефтийн эх үүсвэр тогтоогдсон. Энийгээ бид нар БНХАУ-д экспортолж байгаа. Ингээд энэ гэрээн дээр дотооддоо нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулсан нөхцөлд энэ экспортын түүхий эд Монгол Улсын үндэсний үйлдвэрийг эн тэргүүнд хангана гэдэг гэрээний дагуу бид нефть дам.../минут дуусав./

**Б.Бейсен:** Энхбаяр сайд гүйцээж хариулья 5 номер.

**Ж.Энхбаяр:** Зүүн бүсийн нефтийн бассейнаас энэ нефть боловсруулах Алтанширээгийн нефть боловсруулах үйлдвэрийг хангах шугам хоолойн ажил үндсэндээ хийгдээд дуусаж байна. Ингээд гол нь хөрөнгө оруулалтын тал дээр нэлээн маргаан үүсчихсэн аж ахуйн нэгж Засгийн газар хооронд татварын маргаан үүссэн. Энийг шийдэж чадаагүйтэй холбоотойгоор олборлолт, хөрөнгө оруулалт жоохон хязгаарлагдаад 1 сая тонн хүртэл экспортолж байсан энэ нефть бүтээгдэхүүн 300 мянга хүртлээ багасчхаад байгаа ийм бодит байдал байгаа. Ингээд Засгийн газраас үүрэг өгөгдөөд бас Эдийн засаг, хөгжлийн яам энэ

татварын маргааныг шийдвэрлэх ажлын хэсгийг хариуцуулаад бид ажиллаж байна. Тэгээд энэ ойрын үед энийг шийдэхийн төлөө байна. Эдийн засгийг, 1 минутад ерөөсөө амжихгүй нь дуусчхаад байх юм.

**Б.Бейсен:** Гүйцээж хариулъя. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Бид эдийн засгаа л тэлэх, идэвхжүүлэх ийм зайлшгүй шаардлага хүрсэн. Одоо манай төсвийн урсгал зардал нийт улсын төсвийнхөө бараг 80 гаруй хувийг, одоо хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бараг ирэх онд 90 гаруй хувь нь үндсэндээ урсгал зардал, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардалд орж ирнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 27 онд ямар нэгэн шинэ хөрөнгө оруулалт хийх боломж байхгүй. Одоо хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрөө үргэлжлүүлэх 2.2 их наядын орон зай байгаа. Гэтэл бидэнд 3.6 их наядын хөрөнгө оруулалт хэрэгтэй байдаг.

Тэгэхээрээ үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтуудаа дахин эрэмбэлнэ гэсэн үг. Шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Өнөөдрийн өргөн барьсан төсвийн хүрээ дагаж НӨАТ-ын буцаан олголтын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн хуулийг хүчингүй болгох санал явж байгаа. Хэрвээ энэ хууль дэмжигдвэл бидэнд 1.8 их наядын бас орон зай үүснэ. Хэрвээ дэмжигдэхгүй бол хөрөнгө оруулалтаас.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэлд оруулж ирж байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага ер нь бол хамгийн үрэлгэн төсөв байхаар бол уншигдаж байгаа. Өнгөрсөн жилтэй харьцуулахад энэ удаагийн төсөв бол 10 хувиар нэмэгдсэн буюу 36.5 их наяд болж орж ирж байгаа. Парламентын дэргэд тогтвортой байдлын зөвлөл буюу мэргэжлийн бие даасан эрдэмтэн, доктор, эрдэмтэн судлаачдын ийм баг ажилладаг. Тэгээд энэ зөвлөл нь болохоор Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын тэлэлтийг 4.5 их наядаар бас танах ийм орон зай бол байна гэж дүгнэж байгаа юм.

Тэгэхээр гадаад нөхцөл байдал гээд бид нар ярьж байгаа одоо хүнд байна, дайн дажин болж байна, ойрх Дорнодын асуудал, бензин шатахуун, Ормузын хоолой гээд л янз бүрээр л айдас бид нар ард иргэдийг төрүүлж ирсэн. Тэгээд тийм юм бол энэ бүсээ чангалсан, эрсдэлд суурилсан ийм төсвийн хүрээ орж ирэх юм болов уу гээд харлаа. Харамсалтай нь бол яг тийм манлайлал энэ Засгийн газар үзүүлж чадсангүй гэж хэлмээр байна.

Тэгэхээр зарлага өсөж байгаа. Энэ зарлага өсөж байна гэдэг чинь өөрөө юу хэлж байна гэхлээр аж ахуйн нэгжүүдийн татварыг нэг бол нэмэгдүүлнэ. Хэрэв нэмэгдүүлж чадахгүй байх юм бол энэ Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх ерөөсөө ийм л боломжоор энэ зарлагыг нэмэгдүүлж байгаа юм. Тэгэхээр энэ 26 оны төсөвтэй харьцуулахад 27 оны төсвөө төлөвлөхдөө яг тодорхой хариулж өгөөрэй гэж би хүсэж байна. 26 оны яг ямар ажлуудыг зогсоогоод, багасгаад, шинээр яг ямар ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх вэ? Би энэ дээр тодорхой хариулаад өгөөрэй гэж хүсэж байна.

Манай улстай аж ижил төсөөтэй эдийн засгийн, ийм эдийн засагтай улс орнуудын хувьд бол нийт улсынхаа нийт зарлагаа, төсвийнхөө нийт зарлагыг ДНБ-ий 27 хувь дээр бол барьдаг. Ингээд 27 хувь дээр барьсан нь өөрөө эдийн засгийн тэлэх энэ боломж, орон зайг бас нээж өгдөг өө гэдэг нь бол харагдаж байгаа.

Гэтэл манай улс бол 32 хувьтай оруулж ирж байгаа энэ 27 оныхоо төсвийн хүрээг. Тэгэхээр манай улс тийм баян юм уу гэж би бас асуумаар байгаа юм. Ийм үрэлгэн төсвийг зарцуулаад яг хэдэн ажлын байрыг нэмэгдүүлж байгаа вэ? Бодит цалин хэдээр нэмэгдэх юм бэ? Энэ зарлагаа юунд зарцуулаад байгаа юм? Энийг тодорхой бас мэдмээр байгаа юм. Ядуурлын түвшнийг хэдэн хувиар бууруулахаар яг энэ тооцож байгаа юм бэ? Ингээд эндээс хариултаа авчхаад тодруулъя.

**Б.Бейсен:** 5 номер Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ бол төсөв биш, төсвийн хүрээ. Макро эдийн засгийн гол 9 үзүүлэлтээ л тодорхойлж байгаа юм. Ер нь Монгол Улсын эдийн засаг ингэж өсөх нь, инфляц ингэж явах нь, төсвийн орлого ийм байна, зардал тийм байна, тэнцэл ингэнэ. Нэг зүйлийг хэлэхэд энэ үлэмж өсөлт гээд ийм хүч өгсөн үг хэрэггүй. Энэ Монгол Улсын эдийн засаг жил бүр л 5-7 хувиар тогтвортой өсөж байна. Хүн ам өсөж байна. Энийгээ дагаад цэцэрлэг, сургуулийн хэрэглээ шаардлага өсөж байна. Урсгал зардлууд нэмэгдэж л байна. Энэ бүх юм зүй ёсны төсвийн тусгай шаардлагадаа нийцээд л тооцоо хийгдээд л явж байгаа. Нэг зүйлийг анхаармаар байгаа юм. Өнөөдөр 208 хуулиар зардлыг, урсгал зардлыг хуульчилчихсан. Зөвхөн цалингийн нэмэгдэл гэхэд л 30 орчим хууль дээр байгаа. Байнга нэмэгдүүлэхээр. Эндээс бол бид нар өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Урсгал зардал буух бололцоо байхгүй.

Нэгэнт нэмэгдүүлсэн урсгал зардал буурдаггүй. Багш, эмч нарын цалингийн нэмэгдэл гэхэд л 4 их наядын нэмэгдлийг үүсгэчихэж байна шүү дээ. Түүний эсрэг Монгол Улсын төсөв, Монголын Улсын эдийн засгийн потенциал суурь хэвээрээ байгаа. Ордог орлого олж байна, татвар төлөлт нэмэгдэж байна, экспорт нэмэгдэж байна, импорт нэмэгдэж байна, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд бүгд өндөр байгаа.

Валютын нөөц 7.3 тэрбум байна. Монгол төгрөгийн ханш тогтвортой байна. Хоёр асуудал үүсээд байна.

Нэгдүгээрт, олон улсад үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор шатахууны үнийн өсөлтөөр дагаад инфляцад нөлөөлөл дарамт ороод байна.

Хоёрдугаарт, хэт нэмсэн урсгал зардал, эх үүсвэрээ дутуу тооцож эрс нэмсэн энэ урсгал зардлын нэмэгдэл өөрөө төсөв дээр ачаалал болж хувирч байна. Тэгэхээр суурь зүйл бол байдгаараа л байгаа. Тэгэхээр үлэмж нэмэгдэл гэж юм хаана явж байгаа юм гэдгээ бас их сайн бүгдээрээ хаа хаанаа ярихгүй бол нийгэмд их буруу сигнал, дүгнэлтүүд өгч болохгүй ээ.

**Б.Бейсен:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Нэгдүгээрт, би төсвийн хүрээ асуусан байгаа. Тэгэхээр та миний асуултыг ерөөсөө сайн сонсоогүй хариулт өгч байна гэж би хэлмээр байна. Тэгэхээр хэдүүлээ энэ улсын төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийг хэлэлцэх асуудал дээр энэ төсөв, энэ асуудал бол ерөөсөө тоглоом биш юм гэдгийг бас хаана хаанаа хэдүүлээ ойлгоод явах хэрэгтэй. Бид нар төсвийн хүрээ яриад нийт төсвийн зарлага ярьж байгаа байхгүй юу. Тэгээд би нийт төсвийн зарлагатай холбоотой л тодорхой асуулт асуусан. Төсвийн хүрээг яаж гаргадаг юм бэ? Өнгөрсөн 25 оны гүйцэтгэл, хүлээгдэж байгаа 26 оны гүйцэтгэл нөхцөл байдлыг тусгаж байж төсвийн хүрээгээ тодорхойлдог оо. Тэгэхээр бид нар энэ Монгол

улсын ард иргэдийн энэ амьдралыг сайжруулах гэж байгаа энэ нийт зарлага байж чадаж байна уу гэдгийг л би тодорхой асууж байгаа юм.

Тэгэхээр ингээд би зөвхөн энэ өнөөдөр бид нар салбартай холбоотой асуудал ярьж байгаа учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсөв.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мандхай гишүүнд 1 минут.

**М.Мандхай:** Сүүлийн 10 жилийн хугацаанд төсөв 5 дахин нэмэгдсэн байгаад байгаа юм. Тэгэхээр миний түрүүний асуусан асуулт иргэдийн амьжиргаа сайжирч байна уу? Хөдөө аж ахуйн салбарт маш их хэмжээний мөнгө ингээд төсөв нэмэгдээд сүүлийн 10 жил явжээ. Хөдөө аж ахуйн малчин өрхийн энэ сарын орлого 20 оныг 25 онтой харьцуулсан статистик мэдээлэл байгаа. Нийт орлого нь, нийт зарлага нь орлогоосоо нэмэгдчихсэн буюу малчин өрх жил ирэх тусам өрнөөс өрөнд амьдарч байгаа. Тэгэхээр ингээд уучлаарай сайд нар аа асуух хэрэгтэй өөрсдөөсөө малчин өрхийн амьжиргаа өнөөдөр сайжирч байна уу? Хөрсөн дээр буусан бид нар энэ төсвийн хүрээ, төсвийн төлөвлөгөө, хөгжлийн бодлогоо бид нар тодорхойлж чадаж байгаа юу, бодит үр дүн өнөөдөр хүрч байна уу, ядуурлын түвшнээс буурч байна уу гэдэг ийм тодорхой төсвийн хүрээгээ тооцоод хөгжлийн бодлого, төлөвлөлтөө оруулж ирэхгүй бол ард түмний чинь амьдрал бүүр шалдаа буулаа.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ? 3 номерын микрофон хариулъя.

**С.Даваасүрэн:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн дэд сайд Даваасүрэн. Тэгэхээр та хөгжиж байгаа улсуудын хувьд бол манай төсвийн ДНБ-д эзлэх харьцаа харьцангуй бас өндөр байна гэж хэлсэн. Тэгэхээр олон улсын валютын сагаас 2025 онд гаргасан сүүлийн 5 жилийн дунджаар манай улстай харьцуулахад манай улстай ойрхон байдаг улсуудын хувьд бол төсвийн нийт зардлын ДНБ-д харьцах харьцаа бол 26.4 байна. Монгол Улсын хувьд бол өнгөрсөн 2025 онд энэ тоон үзүүлэлт 26.2 гарсан. Харин 23 онд бол ДНБ-д харьцуулахад 33 хувьтай. 24 онд бол 37 хувьтай байгаа. Тэгэхээр 2027 оны төсвийн хүрээнд бол ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хэмжээгээ 30.4 хувь гэж бол тооцож оруулж ирж байгаа. Энэ дээр.../минут дуусав./

**Б.Бейсен:** 3 номер гүйцээж хариулъя.

**С.Даваасүрэн:** Хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн тухай асуудлыг бас авч хэлж байна. Тэгэхээр төсвийн энэ төсөөлөл дээр та бүхэнд тараагдсан материал дээр байгаа 2027, 28, 29 онд хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг тус бүр 5.4, 4.3, 6.4 гэж тооцсон бөгөөд төсөөлөлд ашигласан хамгийн гол таамаглал бол түрүүн бас Ганхүлэг гишүүний асуултад хариулахад цаг агаарын харьцангуй тогтвортой байж малын зүй бус хорогдол харьцангуй бага байна. Хүнсний хувьсгал, Атар-ын 4 гэсэн энэ аяны хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг болон бүтээмжийг дээшлүүлнэ. Газрын тосны үнийн өсөлтийн нөлөөгөөр газар тариаланд бага зэрэг зардал нэмэгдлээ гэдэг ийм таамаглалыг үндэслээд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд бол Хүнсний хувьсгал, мөн малын эрүүлийг хамгаалах зах зээл дээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ тогтоход бол төр оролцохгүй байх хөдөө аж ахуйн зах зээлийгээ аль болох зах зээлийн зарчмаар хөгжүүлэх, мөн махны нийлүүлэлтийн сувгийг.../минут дуусав./

**Б.Бейсен:** Гишүүд асуулт асууж дуусаж байх шиг байна. Би нэг асуулт асууя.

Одоо энэ өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдчихлээ. Мах 33-аас 38 мянга хүрчихлээ. Тэгэхээр энэ үнэ тогтворжуулах талаар Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яамнаас хөдөө аж ахуйн барьж байгаа бодлого байна уу ер нь? Худалдааны тухай хууль гэж байна уу? Ер нь худалдаж байгаа юмны дээд түвшин тогтооё. Хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улс, Казакстаны худалдааны тухай хуультай юм байна. Нэгдүгээр асуулт. Энийг яаж зохицуулах гэж байна.

Хоёр дахь асуудал энэ төсвийн хүрээний мэдэгдэл яригдаж байгаа учраас манайх газрын тос экспортолж байна. Хэчнээн сая тонн газрын тос экспортолж байна, эргэж төсөвт бүрдүүлэлт орж байгаа энэний орлого гэж байна уу ер нь? Энэ 2 асуудал асууя.

Энхбаяр сайд хариулъя. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Газрын тос олборлож байгаа 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа. Эд нартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулдаг. Тэр бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Монгол Улс өөрт ноогдох орлогоо тогтмол авч байгаа. Татварын маргаан үүссэнтэй холбоотойгоор экспорт эрс багасаад байгаа. Сая тонн хүрч байсан, сая баррель хүрч байсан экспорт одоо 300 мянга руу оччихоод байгаа байдал бий. Энийг засах зайлшгүй шаардлагатай.

Инфляцад 2 оронтой тоонд хүрсэн 10.1 хувиар 4 сарын байдлаар гарлаа. Өнгөрсөн онд 7 хувьтай гарсан. Инфляц өсөхөд гол нөлөөлсөн зүйл бол мах, төмс, хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүн. Хүнсний бүтээгдэхүүний өсөлт инфляцыг өндөр байхад голлон нөлөөллөө. Нийт инфляцад тооцоход 430 гаруй төрлийн өргөн хэрэглээний барааны дундаж үнэтэй харьцуулалт хийж инфляц гардаг. Үүн дотроо хүнсний багц их өндөр гарч байгаа.

Гэхдээ саяын энэ нэр дурдсан 3 барааг Монгол Улс дотоодоосоо бүрэн хангаж тогтворжуулах бололцоотой. Одоо ингээд цаг ирээд мал ногоонд цадаад ирэхээр шинэ махны нийлүүлэлт эрс нэмэгдээд өдөр тутам энэ махны үнэ ханш буугаад эхлэх байх.

Энэ хаврын тариалалтыг бид хариуцлагатай зохион байгуулж, нөөцийн шатахуунаар хангаж, нөөцөд байсан бордоо, ургамал хамгааллын бодисоор хангаж, инфляцын үнэ нэмэгдээгүй тариалалтыг явуулж байгаа. Энэ нь өөрөө энэ намар тийшээ ургац хураах үед манай энэ гурил, гурилан бүтээгдэхүүн, улаан буудай, төмс, хүнсний ногоо, махнаас үүсэж байгаа инфляц тогтворжих ийм бүрэн бололцоотой. Энийг анхаарсан бодлогын арга хэмжээнүүд явж байна.

Нөгөө талаас энэ нийт төсвийн хүрээ гэдэг маань бид Монгол улсынхаа нийт эдийн засгийг үнэлээд, потенциалгаа үнэлээд ийм орлого төсөвт орох нь, үүнээс энийг нь зарах нь, гадаад зээлээр энийг ашиглая, халамжид ийм дээд зардал нь энэ байна. Засгийн газрын өр ийм байна, зохистой хэмжээ нь энэ байна, гадаад зээлийн ашиглалт энэ байна гэсэн л тоонууд шүү дээ. Энэ тоогоо тохироод авах бол энэ дээр тулгуурлаад Сангийн яам энэ зуны хугацаанд ажиллаад төсвөө зохиож орж ирнэ. Салбар салбарыг нь нарийвчилсан.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлээр бол энэ салбарыг нь нарийвчилсан ийм тоо орлого, зарлага дээр бол юм ярих боломжгүй. Ерөнхий эдийн засгийн потенциалгаа гаргаж байна гэсэн үг шүү дээ. Боломж ийм байна. Үүнээс хэтрүүлж болохгүй шүү. Энэ орлогыг заавал биелүүлэх ёстой шүү. Зардлын дээд хэмжээ чинь энэ байна шүү. Гадаад өрийг энэнээс хэтрүүлэхгүй шүү. Гадаад зээлийн ашиглалтыг энэ дотор барь гэдэг л ерөнхий Монгол улсын нийгэм, эдийн засгийнхаа үнэлгээгээ хийгээд л өгч байгаа гол хүрээ, мэдэгдэл, хязгаар нь гэсэн үг.

Тэгээд төсөв яриад ирэхээр бүгдээрээ задлаад яг салбарын асуудлууд, гишүүдийн яриад байгаа асуудлыг бүүр задлаад ярилцах намар тийшээ төсөв өргөн барьсан үед яригдана гэж.

**Б.Бейсен:** Ер нь үнийн өсөлттэй холбоотой энэ бас төсөвт бас нөлөөлөх юм шиг байна. Тийм учраас Худалдааны тухай хуулийг Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хамтарч байгаад энийг боловсруулахгүй бол үнэ тэр Худалдааны хуультай улсууд тэр дээд хэмжээг нь тогтоочихдог юм шиг байна. Тэрийг бид нар бас судалж байгаа. Энийг ер нь Монгол улсад худалдааны тухай хуулийг яаралтай өргөн барих нь зөв юм шиг байна. Энийг бас санал болгож аваарай гэдгээ хэлье.

Гишүүд асуулт асууж дууслаа. Гишүүдээс урьдчилан ирүүлсэн санал байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ундраа танилцуулна. Дараагийн асуудалд оръё.

17.45 цаг

**“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ажлын хэсгийн нэрс.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Ц.Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ц.Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Т.Гантогтох Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Б.Мөнгөнсүх Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Д.Эрдэнэтуяа Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Т.Баясгалан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, З.Райымбек Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга. П.Чандмань

Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, О.Мягмардорж Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, С.Пүрэвсүрэн Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Өлзий Бодлогын газрын дарга, Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга, Ц.Уранчимэг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга, З.Батбаяр Усны газрын дарга, Б.Оюунсанаа Ойн газрын дарга, Э.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Б.Урьболд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас М.Ням-Очир Нийтийн аж ахуй, бодлого зохицуулалтын газрын дарга, Хүн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, М.Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Х.Алтангэрэл Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, “Эрдэнэс Монгол” компаниас Б.Баярдаваа Төслийн удирдлагын газрын дарга, Л.Наранчимэг Эрсдэлийн удирдлагын газрын дарга гээд ийм ажлын хэсэг байна.

“Монгол улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Мандхай гишүүнээр тасалъя. Б.Уянга гишүүн асуулт асууя.

**Б.Уянга:** Энэ өдрийн мэнд хүргэе. Байгаль орчны яамныхнаас энэ усны төслүүдийг энэ 27 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусаж байгаа усны төслүүдийг асууя. 6.3.1.Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулна гээд. Тэгээд гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж усны нөөцийн тархалтыг тогтооно гэж байгаа юм байна. 3.8 тэрбум төгрөг сууж байгаа бололтой. 2027 онд яг хаана энэ усны нөөцийн тархалтыг тогтоож, зураглалын ажлыг өргөжүүлэхээр ажиллаж байна вэ? Ер нь ингээд бүх юм их үнэд орчихсон байгаа. Усны салбарын мэргэжилтнүүд ч гэсэн их цөөхөн. Тэгэхээр ер нь энэ манай салбарын мэргэжилтнүүдийн оролцоо хэр байна? Төслийнхөө та хэдийн гаргаж тавьж байгаа байршил, тэгээд тэнд гарчих арах зардлын хэмжээ хэр их өсөж байна вэ? Ер нь жилдээ хэд орчим байвал энэ газрын доорх усныхаа мэдээллийг Монгол улс шат дараатай нэмэгдүүлж чадах вэ?

Хоёрдугаарх ажил нь болохоор говь хээрийн бүсэд газрын доорх усны ордын нөөцийг нөхөн сэлбэх байгууламжийн төслийг хэрэгжүүлнэ гээд. Энэ төслийг төслийн зүгээр нэрийг уншаад их талархаж хүлээж авч байна л даа. Яагаад гэхээр газрын доорх усыг нөхөн сэргээгддэггүй гээд ташаа ойлголт яваад байдаг. Газрын доорх усны нөөц нөхөн сэргээгдэх боломжтой. Одоо бас тэрийг бас нэлээн тийм техноген байдлаар гаднаас нь гадаргаас усыг нь газрын доор байгаа тэр усны нөөц рүү шүүрүүлэх байдлаар нөхөн сэргээх ийм арга замууд бол

нээгдсэн байгаа. Тэгэхээр яг энэ 6.3.1.2.4-д байгаа нөхөн сэлбэх байгууламжийн төслийг хэрэгжүүлэх гэдэг дээр яг хаана ямар ажил хийх юм бэ? Энэ 2 дээр хариулт авъя.

**Б.Бейсен:** 8 номер Батбаяр Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

**Ш.Батбаяр:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр хариулъя. Усны хайгуулын хувьд олон жилийн турш хийгдээгүй байсан. Тэгээд 27 оны төлөвлөгөөнд тусгагдсанд яамны хамт олон салбарын зүгээс баяртай байгаа. Төсвийг хуулиараа бол усны хайгуулыг улсын төсвийн хөрөнгөөр хийх ёстой. гэж заасан байдаг учраас энэ ажил хувийн хэвшил болон олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж чаддаггүй олон жилийн турш ингэж хоцрогдсон байгаа. Тэгээд говийн бүсэд бол усны хайгуулыг хийх төлөвлөгөөг гаргасан байгаа.

Хоёр дахь асуултад бол хөв цөөрөм дээр бол юу яаж байгаа гишүүн ээ улсын хэмжээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хөв цөөрмүүдийн зураг төсөл, ТЭЗҮ-ийг аймаг орон нутгуудаасаа цуглуулаад говийн болон баруун аймгуудаас голцуу цуг цуглуулсан байгаа. Тэгээд тэрийг нарийн мэдээллийг тан руу бичгээр хүргүүлье.

**Б.Бейсен:** Уянга гишүүн тодруулъя.

**Б.Уянга:** Тэгээд бичгээр авъя. Хөв цөөрмөөс өөр ийм ажил төлөвлөгдсөн байгаад байна лээ. Тэгэхээр танай байгалийн нөөцийн газраас мэдээллийг нь авч байгаад энэ дээр бас яг хэрэгжилтийг нь хянах үүднээс хамтран ажиллах ийм саналыг удахгүй хүргүүлнэ. Тэгээд яах вэ гидрогеологийн гэхээр газрын доорх усны судалгаан дээр яг энэ зураглалын дунд масштабын зураглалын ажлыг л улсын төсвийн хөрөнгөөр хийгээд байгаа тээ? Газрын доорх усны хайгуулын ажлыг болохоор хувийн хэвшил хийж бол болж байгаа. Тэгэхээр бүгдээрээ ялгаагаа гаргаж байгаад бас тайлбарлах ёстой байх. Тэгээд холбогдох мэдээллийг яамнаас нь тодруулахаар авъя даа. Баярлалаа.

**Б.Бейсен:** 5 номер. Энхбаяр сайд тодруулъя, гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлэх зорилтын хүрээнд 2023 онд Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн зарим сумд нутагт 200 мянганы масштабтай зураглалын ажлыг хийж байгаа. Гидрогеологийн зураглалтай газар нутгийн хамрах хүрээг 17.3 хувьд хүрсэн байна гэдэг энэ зорилтын хүрээнд хийгдэж байгаа ажлууд байгаа. Говь, хээрийн бүс дэх газрын доорх усны ордын нөөцийг нөхөн сэлбэх байгууламжийн төсөлтэй холбоотой мэдээ өгье. Багануур дүүрэгт туршилтын төсөл хэрэгжүүлсэн. 26 онд санхүүжилт шийдэж чадаагүй, байхгүй. 27 онд 1 байршил хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд орчихсон явж байгаа.

Говийн усны төслүүдийг ногоон хөгжлийн нь номер 1, 2 гэж эрэмбэлж хамгийн эн тэргүүнд авч үзэж байгаа. Энэ хүрээнд Орхон-Онги төсөл 9 тэрбум төгрөгийн ТЭЗҮ-гийн санхүүжилтийг Байгаль орчны сайд дээр тавиад сонгон шалгаруулалт хийгдээд явж байна. Хэрлэн-Тооно төсөл ТЭЗҮ Эрдэнэс Оюутолгойн санхүүжилтээр 3 сая долларын ТЭЗҮ хийгдээд дууссан. Одоо эцсийн техникийн зохицуулалтууд 4.../минут дуусав./

**Б.Бейсен:** 5 номер гүйцээж хариульъя.

**Ж.Энхбаяр:** Хэрлэн-тооно төсөл бол их чухал төсөл. ТЭЗҮ-г “Эрдэнэс Оюутолгой” компанийн санхүүжилт 3 сая доллар хийгдээд дууссан. 4 хувилбар гарсан. Энийг бид хамгийн үр ашигтайг нь сонгоно. Ер нь энэ төслөө усны төслүүдийг бид COP-17-д танилцуулах тэргүүлэх төслүүд болгож бэлдэж байгаа. Баярлалаа.

**Б.Бейсен:** Мандхай гишүүний асуулт асууя.

**М.Мандхай:** Энэ хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотойгоор Хөдөө аж ахуйн сайдаас асууя. Монгол Улсыг 26-аас 30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Их Хурлаар батлуулсан. Тэгээд ажлын хэсэгт нь бас идэвхтэй ажилласан. Миний хувьд бол энэтэй холбоотойгоор энэ үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт зорилт түвшинд энэ хөдөө аж ахуйн салбар дараах шалгуурыг тусгасан байгаад байгаа юм. Малын чанарыг сайжруулна. Нийт малын тоонд өндөр ашиг шимт малын эзлэх хувийг 24 онд 5.3 хувь байгааг 27 онд 8, 30 онд 11 хүрэхэд хүргэх, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах. Ингээд 24 онд 12.5ц га байсныг 27 онд 13.2, 30 онд 14 гээд. Ингээд тариалсан талбайгаас хураасан ургац гээд дандаа ингээд ахисан ийм бүтээмжийг нэмэгдүүлсэн үзүүлэлтүүд байгаа.

Гэтэл энэ Монгол Улсыг хөгжүүлэх 27 оны төлөвлөгөөнд тусгасан үр дүнгийн зорилтот түвшин дээр дээр дурдсан саяын таван жилийн энэ зорилтот түвшин шалгууруудтай ерөөсөө нийцэхгүй харагдаад байна. Жишээлэх юм бол малын сана чанарыг сайжруулахаар 31 судалгаа хийх, 1 үнэлгээний тайлан гаргах, барилгын ажлын гүйцэтгэлийн 50 хувьд хүргэх, мөн газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг зорилгоор санхүүгийн дэмжлэг олгоход хамрагдсан үйлдвэрлэгчдийн тоог 27 онд 505 хүргэнэ гээд ийм л үзүүлэлтүүд оруулчихсан байгаа юм.

Тэгэхээр энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиараа Монгол Улс энэ таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилтот түвшин буюу энэ хүлээгдэж байгаа үр дүнтэй нийцүүлээд яг ямар төлөвлөгөө яам баталж ажиллах ёстой. юм бэ? Ийм баталсан төлөвлөгөө байгаа юу? Байгаа бол энэ төлөвлөгөө Улсын Их Хурлаас баталсан таван жилийн энэ чиглэлтэй яагаад нийцэхгүй байгаа вэ гэдэг асуултыг асууя. Мөн цаасан дээр энэ баталсан бодлого амьдрал дээр угаасаа мэдээж хэрэгжих ёстой. Тэгэхээр энэ Засгийн газар өөрөө Улсын Их Хурал руу энэ хэрэгжихгүй байгаа бодлогын төсөл оруулж ирдгээ болихгүй юм уу? Эндээс асууя.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ? Идэрбат сайд хариульъя.

**Ц.Идэрбат:** Мандхай гишүүний асуултад хариульъя. Монгол улс Алсын хараа-2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөө ингээд олон бичиг баримтуудын, эрх зүйн бичиг баримтуудын хүрээнд аливаа хөгжлийн бодлого төлөвлөгддөг болсон. Үүнээс хазайсан, үүнээс хилийн давж гарсан, эсвэл огт хэрэгжихгүй зүйлийг төлөвлөх тийм үйл явц бол энэ эрх зүйн өөрчлөлтүүдийн хүрээнд бол бий болчихсон гэж ингэж ойлгож болно.

Манай хөдөө аж ахуйн салбар дээр таны яг тухайлан асуусан малын чанар, газар тариалангийн салбарын өсөлт дээр бид бүхэн бас онцгой анхаарч ажиллана.

Энэ 2027 оны төлөвлөгөө дээр ч тэр, таван жилийн төлөвлөгөө дээр ч бас тусчихсан байгаа. Малын чанарын асуудлыг ярих юм бол бид нар өндөр ашиг шимтэйгээс гадна өнөөдөр бэлчээрийн мал аж ахуйгаар адгуулагдаж байгаа энэ мал аж ахуйгаа ч бас малын чанар ашиг шимийг сайжруулах тал дээр үүнийгээ дагаад малчдын орлогыг нэмэгдүүлэх тал дээр тодорхой бодлого, шийдвэрээ гаргаад эхнээс нь хэрэгжилтийн үйл явц руугаа ороод ингээд явж байгаа. Тийм учраас бид бас 27 оны төлөвлөгөө дээр тодорхой үр дүн гарах учраас бас энэ асуудлуудыг бас оруулаад ингээд явж байгаа.

Газар тариалангийн тогтвортой хөгжил гэдэг асуудлыг яривал бас их том хүрээ юм билээ. Яг өнөөдөр төрийн ингээд байдлаараа бид нар байнга татаас өгдөг, татаас нь эргээд янз янзын хар сэрд гаргуулдаг олон зүйлүүд бас байгаа. Тэгэхээр татаасны асуудлыг ер нь цаашдаа аль хүрээд зогсох юм бэ гэдгийг бол Засгийн газрын тэргүүнээс авхуулаад бас энэ хөдөө аж ахуйн салбар дээр хэрэгжиж байгаа олон төслүүд дээр бол тодорхой болго гэдэг ийм зүйл байгаа. Чиглэл өгсөн байгаа.

Үүнийхээ хүрээнд бид нар газар тариалангийн энэ хөгжлийн асуудлыг энэ төрийн дэмжлэгээр явж байгаа энэ хөгжлийн олон хөтөлбөрүүдийг гэнэт таслах биш тодорхой хэмжээнд үргэлжлүүлээд энэ хүрээд зогсоно гэдэг төлөвлөгөө бид гаргаад тэгэхдээ үүний гол учиг бол ер нь бид дотоодынхоо хэрэгцээг бол ер нь 100 хувь хангадаг. Ган болохгүй л бол хангачхаад байна шүү дээ. Гадагшийгаа экспортын чиг баримжаатай газар тариалан гэдэг энэ асуудлыг хөндөж тавиад энэ 2024 он онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Ургамал хамгааллын хууль, түүнтэй уялдуулаад гарсан Ургамал хамгааллын газартайгаа энэ экспортын чиг баримжааг хөгжүүлэх тал дээр бас нэлээдгүй ахицууд гаргаж эхэлж байгаа юм. Энэ хавраас авхуулаад хөрш улсуудтайгаа энэ харилцан бүтээгдэхүүн гаргах энэ протоколын асуудлуудыг хүртэл үзэж байгаа. Тэгэхээр газар тариалангийн хөгжлийн тогтвортой байдал гэдгийг бол бид зөвхөн дотоодын хэрэгцээ гэж харахгүйгээр, экспортын чиг баримжаатай байж энэ тогтвортой хөгжинө гэж ингэж харж байгаа учраа нөгөө талдаа хөрөнгө оруулалтын чиглэлүүдийг бид нар газар тариалангийн салбарын гол хүндрэл болсон байгаль, цаг уурын энэ гэнэтийн гангаас.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Тэгэхээр шинэ сайдад хийх ажил маш их байна. Хөгжлийн төлөвлөгөөг нэлээн үр дүнтэй ард иргэдийн яг амьдралыг сайжруулахуйц, малчин өрхийн амьдралыг сайжруулахуйц ийм хөгжлийн төлөвлөгөө болгож, үр дүн гаргах ийм төлөвлөгөөтэй, төлөвлөгөө тэгээд мөн хэрэгжилттэй байгаасай гэж хүсэж байгаа юм. Би тэгээд түрүүн таныг байхгүй байхад ярьсан л даа. Сүүлийн 10 жилийн хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсөв 5 дахин нэмэгдсэн байгаа. Өнөөдөр 20 оныг 24 онтой харьцуулсан статистик тооцоогоор малчин өрхийн орлого, зарлага нь орлогоосоо нэмэгдээд жил ирэх тусам ер нь нэмэгдээд яваад байгаа. Тэгэхээр энэ төсвийн мөнгө яг бодит амьдрал дээр бууж байгаа юм уу яг малчин өрхийн амьдрал сайжирч байгаа юм уу гэдэг асуудалд хариулах ёстой. өнөөдөр.

Хоёрдугаарт, сүүлийн 5 жилийн хугацаанд энэ татаас хөдөө аж ахуйд олго.../минут дуусав./

**Ж.Энхбаяр:** Идэрбат сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** Энэ хөдөө аж ахуйн салбарын төлөвлөгөөг батлахдаа бид бол аль болох амьдралтай ойрхон байх, амьдрал дээр хэрэгжих бололцоотой ийм зүйлүүд рүү бол бас анхаарлаа хандуулж байгаа. Төлөвлөгөөг уран гоё гэхээсээ илүүтэйгээр энэ бодит байдалд яаж тусах вэ гэдэг рүү ер нь манай яам чиглэж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй.

Малчдын амьдрал, малчдын гар дээрх орлогыг нэмэгдүүлэх асуудал бол өнөөдөр зөвхөн ноолуур, махны орлого л энд нөлөөлж байгаа тийм ээ. Манай яамны хувьд бол энэ үнэгүйдээд байгаа арьс, шир яснаас нь авхуулаад энэ хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнийг үнэ цэнтэй болгох, орлогыг нь нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж ажиллана. Салбарын төсвийн хувьд бол өсөлт харагдаж байгаа нь бас бодитой.

Нөгөө талдаа үүний үр дүн юу байна гэдэг нь бол энэ хаврын ноолуурын асуудал байгаа. Энэ ноолуурын салбарыг ингэж татаасаар дэмжиж өгч энэ Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд монгол ноолуур жилээс жилд өсөж байгаа. Тэгэхээр энэ салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай байгаа тат.../минут дуусав./

**Б.Бейсен:** Нэмж Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Малчдын амьдрал ямар байна? Мал аж ахуй Эрхэлж байгаа малчдын амьдралд орлогын өсөлт тогтмол нэмэгдэж байгаа. Мах, ноолуур, зөвхөн мах, ноолуурын асуудал биш төрийн бүхий л үйлчилгээг малчдад хүргэж байгаа. Эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа, үйлчилгээ, мал эмнэлэг бүгд татвар төлөгчдийн мөнгөөр тэнд очиж байгаа. Энэ бас өртөгт тооцох ёстой.

Хоёрдугаарт, малчдын НДШ-ийн 50 хувийг мөн л татвар төлөгчдөөр төлж байгаа. Малын хөлийн татвараас авхуулаад ер нь таатай эдийн засгийн бэлчээрийн үнэ төлбөрийг ашиглахаас авхуулаад бүхий л бололцоогоор төр хангаж байгаа. 25 оны гүйцэтгэлээр орлого хаана нэмэгдсэн бэ гэвэл хөдөө нэмэгдсэн. Хөдөөд 10-аас дээш хувиар нэмэгдсэн. Хотод 2 хувь нэмэгдсэн. Хот суурин газрын иргэдийн орлого сайн нэмэгдэж чадсангүй. Хөдөөгийн иргэдийн орлого болон.../минут дуусав./

**Б.Бейсен:** Энхбаяр сайд гүйцэж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр цаашдаа бид улам л хөдөө аж ахуйгаа энэ байгаль, цаг уур эрсдэлээс хамгаалах, дасан зохицох, сөрж давах тийм л чадавхтай болохын төлөө л бүгд хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж өгнө. Хөдөө аж ахуйн салбар дээр нийт 34 төсөл, арга хэмжээний санал ирснээс 32 төсөл, арга хэмжээ, 413 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ 27 оны төсөвт суухаар ингэж орж ирж байна. Энэ хүрээнд энэ хөдөө аж ахуйн үйлдвэр, технологийн паркаас авхуулаад Цагаан алт, "Атар"-ын 4, Хүнсний хувьсгал, энэ жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, хүнсний хангамж, аюулгүй байдал гээд энэ бүхий л бодлогын арга хэмжээнд туссан энэ бодлого тогтвортой цааш үргэлжилнэ. Ингэж тогтвортой үргэлжилж байж энэ салбарын өсөлт тогтвортой байдал хангагдана. Энийгээ дагаад малчид, тариаланчид, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ор.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Одоо яах вэ ингээд өсөж байгаа, ингэж байгаа гээд ярьж байгаа. Гэхдээ нөгөө талдаа би сая дахиад л тодорхой хэлье. Малчдын зарлага орлогоосоо давчихсан, жил ирэх тусам зарлага нь нэмэгдээд буюу малчид маань худалдан авах чадвар байхгүй, бодит амьдрал нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй, орлого нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй, ядуурлын түвшин 35 хувь 22 онд байсан статистик, өнөөдөр уул нь статистикийн газраас хүн заавал ирж суух ёстой байхгүй юу. Бид нар энэ тоонуудыг бататгаж заавал асуух ёстой. Тэгэхээр дараагийн удаа бид нар хэлэлцэхэд бол Статистикийн газраас хүмүүс тоогоо бататгаж ярихгүй бол орлого нь нэмэгдээд байна, сайхан болоод байна гээд байна. Уучлаарай хэдүүлээ жоохон хөрсөн дээр бууж төсвөө ярьдаг болохгүй бол яг үнэнээ хэлэхэд бид нар харин удахгүй ард иргэд чинь жагсахад бэлэн байгаа шүү гэдгийг би дахиад сануулъя.

**Б.Бейсен:** 5 номер Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ойлголтын зөрүү гараад байна. Малчид банкнаас зээл авч чадаж байна гэдэг чинь их сайн үзүүлэлт. Энэ бол дундаж орлоготой байна л гэсэн үг. Малчид хэрэглээний зээлүүдийг хангалттай авч байна. Оюутны, сургалтын, автомашины, цахилгаан барааны, тэгээд орон сууцын зээлүүдийг авч байна. Энэ сайн үзүүлэлт шүү дээ. Эдийн засаг өндөр хөгжилтэй орнууд энэ зээл авах чадавхтай иргэд нэмэгдэхэд энэ эдийн засгийн сайн үзүүлэлт болдог. Зээлийн хэмжээ нэмэгдэж байна гэдэг чинь тэр хэмжээгээр материаллаг ахуй амьдралын чанарын өөрчлөлтүүд, дэвшлүүд гарч байна гэсэн үг шүү дээ. Энэ муу зүйл ердөө биш.

Хамгийн гол нь тэр зээлээ эргэн төлж байна уу гээд харахад чанаргүй зээлийн үзүүлэлтээр хөдөө хамгийн бага 5 хувиас хэтрэхгүй байна. Тэгэхээр зохистой байна гэсэн үг. Энэ ердөө муу зүйл биш. Малчид маань ноос, ноолуур, мал аж ахуйн гарал түүхий эдийн бүтээгдэхүүнээрээ амьдралаа авч яваад, өөртөө хөрөнгө оруулаад машин тэргээ, амьдрах орчноо сайжруулаад, хүүхдээ .../минут дуусав./

**Б.Бейсен:** Идэрбат сайдад нэмж хариулъя.

**Ц.Идэрбат:** Тийм малчны орлогын асуудал дээр бас Мандхай гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Бид энэ малчны орлого бол яг үнэндээ хаврын ноолуур, намрын мах, хаврын махан дээр л байгаа шүү дээ. Тийм. Тэгээд яг хөдөө орон нутгаар явахад бол малчдын гол ярьж байгаа юм бол энэ махны экспорт гэдэг зүйлийг битгий зогсоогоорой гэдэг ийм л зүйл. Тэгэхээр энэ мах, ноолуурын асуудал бол ингээд малчдын орлогын гол түлхүүр болоод байна. Цөм болоод байна. Яг манай яамны хувьд бол ингээд сарын дараанаас яах ноосны асууд, энэ 10 жил хаягдаж байгаа арьс ширний асуудал, тэгээд энэ малын түүхий эдийг маань үнэтэй болгоод өгчихвөл төрөөс өөр гуйгаад байх юм байхгүй гэж малчид ярьдаг.

Тийм учраас манай яамны хувьд бол яг л амьдрал дээр байгаа тэр харганын үзүүрт өлгөгдчихөөд байгаа ноосыг, хаягдаад байгаа тэр арьс, ширийг энэ эдийн засгийн эргэлтэд оруулж, малчдын орлогыг бодитой нэмэгдүүлэхийн төлөө л энэ.../минут дуусав./

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** 2027 онд юу хийх вэ, юу руугаа гол чиглэж анхаарах вэ гэдэг тухай хэдүүлээ бас ярьж байна. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнгээ хараад цаашаа үргэлжлүүлэх асуудлуудаа цэгцлэх гэдэг ийм бас агуулга яригдаж байна. Ялангуяа 4-н хөтөлбөрийн Хүнсний хувьсгалын хөтөлбөрийг бас дурдаж оруулсан байна. Хүнсний хувьсгал-2 гэж бас арай шинэ зохион байгуулалтад ороод явна гэж харж байгаа юм байна. Яам энэ дээр бас ямар нарийн тооцооллууд байна вэ? 4-н хөтөлбөр гэж уул нь тооцоод байгаа. Тэгэхдээ ингээд 3-ыг нь анхаараад л нэгийг нь ингээд тийм айлын шоовдор хүүхэд шиг л ингээд л болгоод байна л даа.

Тэгээд яг үндсэндээ явж явж та бүгд бүгдийн яриад байгаа малчдын гар дээр бодитоор 20, 30 хувийн хүүтэй очдог байсан зээлийг нь 6 хувь болгож бууруулаад энэ зудын эрсдэлийн эсрэг гар мухар байсан малчид маань өөрсдөө хашаа саравчаа барих, худаг усаа гаргах, жижиг аж ахуй эрхлэх энэ боломжийг нь олгох хамгийн бодитой л хөтөлбөр юм байгаа юм. Тэгээд Шадар сайдын ажлын алба байгаа юм болов уу? Ажлын чиг үүрэг юмнуудаа ерөнхийдөө ядаж энд 1 агуулга оруулаад тусгачхаж болохгүй байгаа юм уу? Шинэ хоршоо хөдөлгөөн гэдэг Монголын олон мянган малчид нэгдэж нийлээд, 30 гаруй малчид нь зээлдээ хамрагдаад, хадлан тэжээлээ өөрсдөө бэлддэг болоод сайн олон туршлагууд бас байгаа л даа. Та хэд маань яг энэ орон нутгаар, энэ хоршоонуудаараа, малчдаараа яваад үзмээр байна. Тэгээд энийг улс төр талаас нь хараад байх юм. Яг үндсэндээ бодитойгоор малчдад хөрөнгө оруулалтын боломж олгосон сайн туршлагуудын тухай ерөөсөө бас бид нар ярихгүй бас байгаад байна. Тэгээд энэ тухай асуудлыг та хэд маань эргэж хараад түүнтэй холбогдолтой заалт, мэдээллүүдийг оруулмаар байна.

Хэрвээ энэ Шадар сайдын ажлын алба энэ ажлыг хийж чадахгүй бол мэргэжлийн яамандаа эртхэн өг өө. Уул нь энэ олон яамнуудын уялдаа холбоог хангаад ингээд Шадар сайд хариуцаад Монголбанк нь орж ирээд ингээд энэ хөтөлбөрийг бусад хөтөлбөрөөсөө илүү өндөр түвшинд авч хэрэгжүүлнэ гэж бодож салбар дундын зохицуулалт гэж харж үндсэндээ тэнд байлгаж байгаа. Тэгээд үнэхээр болохгүй байгаа бол энийгээ ингээд чиглүүлээд яв аа. 100 гаруй мянган хоршоонууд байгуулагдчихсан. 30 мянган зээлээ авчихсан. Дахиад 70 мянган хоршоод зээлээ авах юм уу хоршооноосоо болих юм уу гээд. Хуучин хоршоо, шинэ хоршоо гэдэг ийм ойлголтууд гарч ирээд ингээд бид нар эхлүүлсэн ажлаа жилийн дотор, 2 жилийн дотор ингээд үндсэндээ үр дүнг нь үзэхгүй яваад байх юм бол наадах чинь болохгүй.

Тооцоо, судалгаагаа гаргаад энэ хөтөлбөрийн үр шим, боломж, болохгүй байгаа юмнуудыг нь ил тод гаргаад ингээд цэгцлэх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ 2027 оны энэ төлөвлөгөөнд шинэ хоршоотой холбогдолтой энэ сургалтын ажлуудыг зохион байгуулах, дундын хоршоог дэмжих ийм агуулгуудыг тусгаагүй байна уу? Би дутуу хараад байна уу? Тэгээд энэ дээр та хэд маань тайлбар өгөөд шийдлээ эртхэн гаргаад.../минут дуусав./

**Б.Бейсен:** Хэдэн номероор хариулах вэ? Идэрбат сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** Хөдөө аж ахуйн салбар дээр өнгөрсөн жилүүдэд хэрэгжиж байгаа 4-н том төсөл байгаа. Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атар-ын 4 дүгээр аян, Шинэ хоршоо. Энэ Шинэ хоршооны төсөл бол яг Шадар сайдын ажлын албан дээр байгаа. Шадар сайдын ажлын албанаас бол энэ Шинэ хоршоог цааш нь яаж хөгжүүлэх вэ, амь оруулах вэ гэдэг тал дээр бол эхний төлөвлөгөөгөө гаргаад,

танилцуулаад, ингээд явж байгаа. Шинэ хоршоонд олгосон 840 гаруй тэрбум төгрөгийн хүүгийн татаасанд хөдөө аж ахуйн сайдын багц дээрээс 75 тэрбум төгрөгийг арилжааны банкнуудад бид олгоод ингээд явж байгаа. Энэ зээлийг цааш нь үргэлжлүүлэх асуудал бол Улсын Их Хурлаас хэрвээ шийдэж өгвөл явах бололцоотой гэдгийг бас хэлье.

Нөгөө талдаа энэ шинэ хоршооны асуудал дээр хөдөө аж ахуйн яам ч гэсэн бид энэ малчдын мал аж ахуйн салбар руу хийх гэж байгаа энэ том зорилтот ажлынхаа хүрээнд ч гэсэн энэ хоршооны, хоршоо байгуулагдсан хоршоод дээрээ тулгуурлаж бас эхний алхмуудыг хийе гээд “1000:100” гэдэг хөтөлбөрийг бас улс орон даяар танилцуулаад ингээд явж байгаа. Тэгээд үүнээсээ энэ зөвлөгөөнийг дуусгачхаад 5 сарын 25-наас хойш Байнгын хорооддоо ер нь танилцуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Тэр үеэр бас нэлээн юм тодорхой болох байх гэж ингэж бас бодож байна.

Нөгөө талдаа энэ нэгэнт байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааг бид энэ салбар дээр хэрэгжиж байгаа гаднын энэ төсөл, зээл, тусламж энэ ангилал руу бас ингээд оруулаад цаашаа явах бололцоо бол бүрэн дүүрэн байна гэж ингэж бол харж байгаа. Энэ манай салбар дээр хэрэгжиж байгаа энэ төслүүдийн зарим зориулалтыг нь энэ хоршоо руугаа тулгуурлах, цаашид үргэлжлэх боломжийг нь бас нээж өгөх ийм бололцоо бол бас гарч байна гэж ингэж бас харж байгаа.

Хүнсний хувьсгал, Цагаан алт гээд энэ 2 хөтөлбөр маань Хүнсний хувьсгал бол Их Хурлын тогтоол нь 2022-2026 он байгаа. Тэгээд энэ хугацаанд бас амжилттай хэрэгжиж, 53 шинэ үйлдвэр 1000 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа. Үүнийгээ бид дараагийн алхам бол энэ “Хүнсний хувьсгал 20” гэдэг нь бол Евро Азитай холбоотой бас л экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх нь энэ үйлдвэрүүдийн цаашдын хөгжилтэй улс орны экспортын орлоготой холбоотой юм гэж үзэж дараагийн алхам нь байгаа гэж ингэж харж байгаа.

Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд бол энэ хугацаа нь хэрэгжээд 2 жил болж байгаа. Бид энэ ноосны салбар дээр жишээ нь Цагаан алтны хөтөлбөрт хамрагдсан үйлдвэрүүдээс гарч байгаа бүтээгдэхүүний үнийг дотоодын хэрэгцээгээ хангах тэр Тендерийн хууль дээр цахим дэлгүүр гэдгээс авхуулаад дотоодынхоо хэрэгцээг энэ үйлдвэрүүдээсээ хангах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар оруулаад шийдвэрийг нь гаргуулчихсан явж байгаа.

Нөгөө талдаа ноолуурын үйлдвэр бол угаах, самнах гэдэг энэ процесс 2 жил бас амжилттай хэрэгжээд ноолуурын экспорт ноолуураас орж ирж байгаа орлого нэмэгдэж байгаа. Дараагийн алхам бол бид ээрэх шатын асуудлыг бас энд гаргаж ирнэ гэсэн ийм бодолтой яв.../минут дуусав./

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Идэрбат сайдын эхлүүлж байгаа ажлуудыг бас дэмжиж байгаа. Сая бас зүүн бүсийн зөвлөгөөн амжилттай бас болсон. Иргэд, салбарынхан бас нэлээн мэдээллүүд авсан.

Нарийвчлаад асуувал зөндөө олон зүйлүүд байна. Ямартай ч энэ хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэх, тэгээд хооронд нь бас ялгаад байхгүйгээр нэгдсэн зохион байгуулалтад оруулаад явах тал дээр Засгийн газар дээр сайдууд маань

бас бас анхаараад чигийг нь гаргаж өгөөсэй гэдэг ийм бас хүсэлтэй байна. Тэгээд энэ дээр бол үндсэндээ Шинэ хоршоотой холбогдолтой 27 онд төлөвлөсөн юм огт алгаа. Бид нар 100 гаруй мянган үндсэндээ хоршооны тухай ярьж байгаа шүү. Тийм. Тэгээд энийг их сайн анхаараарай гэдгийг хэлье.

Атар-ын 4, Цагаан алт гээд энэ 4-н хөтөлбөрийн 3 нь мөнгөн дүн байхгүй. Атар-ын 4 болохоор мөнгөн дүнтэй 65 тэрбум гээд орсон байна. Тэгээд энэ зарим нь ингээд мөнгөн дүнтэй, зарим нь мөнгөн дүнгүй бас байгаа нь ямар учир шалтгаантай юм бэ гэдгийг бас асууя.

Бэлчээр хамгаалал, хөрс хамгааллын чиглэлээр боловсон хүчний чиглэлээр хөдөө аж ахуйн боловсон хүчний чиглэлээр юу юу туссан байгаа вэ гэдгийг.

**Б.Бейсен:** Идэрбат сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** Хөдөө аж ахуйн боловсон хүчний асуудал бол ганцхан газар тариалан биш. Ер нь нийт энэ салбарын боловсон хүчний асуудал бол туйлын хүнд болчихсон юм билээ. Тэгэхээр ер нь цаашдаа хөдөө аж ахуйн энэ бодлого энэ сургуультайгаа эрдэм шинжилгээнийхээ байгууллагатай цогцоороо байж байж энэ бид нар боловсон хүчний асуудал ярихаас биш сургууль нь өөр газар, эрдэм шинжилгээний хүрээлэл нь өөр газар байж энэ хөдөө аж ахуйн хөгжил гэж ярихад бол бас туйлын учир дутагдалтай юм билээ гэд гэдгийг би шулуухан хэлэх нь зөв байх.

Нөгөө талдаа энэ Цагаан алт хөтөлбөр энэ үндэсний хэрэгжиж ирсэн энэ хөтөлбөрүүдийг одоо хэзээ, яаж аль хүртэл явах вэ гэдгийг бид эхлээд тодорхой болгох ёстой. Салбарын энэ холбоонуудтайгаа бол энэ талаараа ярилцаад ер нь төрийн дэмжлэг аль хүрээд зогсох вэ гэдгээ хэдүүлээ тодорхой болгоё гээд ингээд ер нь бол аль хүрээд бид аль хүртэл дэмжээд ингээд зогсох юм бэ гэдгээ бол тодорхой болгосон.

Төсөв, санхүүгийн хувьд бол эргээд бас төсөв яригдах үед бас тавих хэдий хэмжээний юм тавих вэ гэдэг нь.../минут дуусав./

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Тэр саяын зүүн бүсийн зөвлөгөөн дээрээс харж байхад “1000:100” хөтөлбөрийг бол үнэхээр дэмжиж байна лээ. Сайд бас энийг үнэхээр ажил болгоорой та. Тэгээд одоо бас энэ хоршооны бас зээлээр тоног төхөөрөмж нэлээн авчихсан байгаа малчдын хувьд ер нь бол бас өөрсдөө хадлан тэжээлээ тариад бэлдэх бас харьцангуй бас боломжууд бас нээгдсэн байгаа. Зудын эрсдэлийг бууруулах хамгийн зөв арга хэмжээ нь энэ болно гэдгийг бас онцлоод бас хэлье.

Хөдөө аж ахуйн сургуулийн харьяа Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн дээр олон наст үрийг өсгөх чиглэлийн төслүүд бас нэлээн олон жилийн хугацаанд бас хийгдээд ингээд тодорхой үр дүн гарчихсан байгаа. Тэгээд энэ бас хөгжлийн төлөвлөгөө дээр энэ бэл бэлчээрийн ургамал тариалахтай холбогдолтой бас энэ үр сортын чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлыг бас тусгасан байна. Тэгэхээр энэ эрдэм шинжилгээний байгууллагынхаа бас ажилтан, албан хаагч нартай өнгөрсөн 7 хоногт Төрийн нарийны хамт бас уулзахад бас ярьж байна лээ. Тэгээд

энийг бас тусгаж аваад ажилдаа бас хэрэгжүүлээсэй гэдгийг бас сануулж хэлэх гэсэн юм.

**Б.Бейсен:** Батчимэг гишүүн асуултаа асууя.

**П.Батчимэг:** Өнгөрсөн чуулган дээр 2027 оны хөгжлийн төлөвлөгөөний хүний хөгжил бүлгээр Аубакир сайдаас асуулт асууж бас жоохон доромжлол үзсэн. Одоо бодвол Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдаас асуулт асууя. Яг энэ бүлгээс тэгээд таны хариултыг сонсьё доо. Хүний хөгжил, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, тэгээд байгаль орчин, ногоон эдийн засаг гэсэн энэ бүлгийн хүрээнд хэд хэдэн асуудлууд тусгасан. Энэ төсөл, арга хэмжээний талаар танаас тодруулга, тайлбар авъя.

Нэгдүгээрт, 2.1 дээр зохистой хөдөлмөр эрхэлж байгаа хүний тоог нэмэгдүүлэх, энэ үр дүнгийн хүрээнд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гээд энэ төсөл арга хэмжээнүүдэд ороод ирсэн. Санхүүжилт нь 100 тэрбум. Тэгвэл хэчнээн аж ахуйн нэгжид яг ямар хэмжээний зээлийг олгох юм, энэ зээл олгох үндсэн шалгуурууд нь юу байх юм, тэр зээлийн хүү хэд байх юм хугацаа нь ямар байх юм бэ гэдэг дээр, тэгээд зээлийн эргэн төлөлт энэ тал дээр та хариулт өгөөрэй.

Стандартын шаардлага, 5.3 дээр стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, тэгээд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх энэ хүрээнд энд энэ хөдөө аж ахуй Хөдөөгийн хөгжлийн төсөл гээд 2 гээд ороод ирсэн. Тэгэхээр бодвол суурь түвшин алга, харагдахгүй байна. Тэгвэл энэ хөгжлийн төсөл 2 гэж байхыг бодоход, ороод ирэхийг бодоход санхүүжилт нь 47.6 тэрбум, урд талын тэр 1 дүгээр төсөл ямар төсөл байсан бэ, хэдэн онд хэрэгжиж байсан бэ? Энэ талаар тодруулга авъя.

Энд бас л адилхан хэчнээн аж ахуйн нэгжийг хамруулах юм, ямар хэмжээний зээл өгөх юм тэгээд санхүүгийн дэмжлэг нь яаж олгох юм бэ? Зээлийн үндсэн шалгуур, зээлийн хүү гээд энэ дээр дахиад аль аймаг аль одоо, орон нутагт ямар ямар аймгуудыг хамруулсан бэ гэж.

6.3 дээр байгалийн нөөцийг судалж хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулах гээд. Тэгвэл энэ “Нутагтаа эзэн 100:1000” гэдэг төслийг хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. 20 тэрбум төгрөгийн санхүүжилттэй. Энэ яг ямар учиртай төсөл юм бэ? Сая зүүн аймгийн чуулга уулзалт боллоо гэлээ. Та зүүн аймгаас тойргийн сонгогдсон гишүүн. Тэгвэл та хангайн бүс буюу бусад бүсдээ хэзээ очиж ажиллах юм бэ? Дандаа зүүн аймгаас дандаа таны ажил эхлээд л ингээд яваад байх юм уу даа? Тийм.

Дараа нь Улсын Их Хурлын энэ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд бид нар 2024 онд баталчихсан байгаа шүү дээ. 64 дүгээр тогтоолоор. Тэгвэл энэ Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг бол хангайн бүсэд багтсан. Тэгвэл хангайн бүсийг уламжлалт энэ мал аж ахуйн төрөлжсөн бүс болгох, хот байгуулалтын дэд бүс болно гээд бүүр үзэл баримтлал тодорхой заачихсан байгаа юм. Хангайн бүсийг дэмжих чиглэлд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл дээр зөвхөн 103 ч билүү 108 худаг л тавигдчихсан байх юм. Энэ үнэхээр.../минут дуусав./

**Б.Бейсен:** Идэрбат сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** Нэгдүгээр асуулт Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ ЖДҮ-гийн зохистой хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд энэ ЖДҮ-гийн зээлийн асуудлыг тодруулж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл бол урт удаан түүхтэй. Сайн, муу олон түүхүүд байгаа. Тэгээд 2022 оноос эхлээд өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явдаг ийм болсон. Тэгээд энэ жилээс бол 20, 30 гаруй тэрбум төгрөгийг 15 аймагт бол олгоод ингээд явж байгаа. Ирэх оных дээр бол яах вэ төсвийн эх үүсвэрээр 100 тэрбумыг нэмье гэсэн саналыг бол яамны зүгээс бол хүргүүлсэн юм байна лээ. Тэгэхдээ энэ бол би бол их тийм шаардлагагүй гэж бол үзнэ. Яагаад гэвэл өмнө байгаа энэ зээлүүдийн энэ эргэн төлөлтөөсөө дараа дараагийн зээлээ өгөөд явах бололцоо бас гарна. Их Хурлын гишүүд нэмэх ёстой гэж үзвэл хэрэгжүүлээд явахад бэлэн.

Нөгөө талдаа ЖДҮ эрхлэгчдийн зээлийн нөгөө хүү, нөхцөл, хугацаан дээр бол маш том. дэвшил гаргасан гэж ингэж бас хэлнэ. Яагаад гэвэл 5 жилийн хугацаатай байсан зээлийг 8 жил болгодог, эхний жил нь эргэн төлөлтийг нь бас хойшлуулдаг гэх мэтээр үнэхээр энэ зээл авсан хүн бол бизнес нь тогтворжоод яаж төлнө өө гэж санаа зовохгүйгээр санасан, бодсоноо хийгээд ашгаа олдог байх ийм зүйлийг бас нэмээд ингээд явж байгаа.

Дараагийнх нь тэр стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ гээд бас заалт орсон байгаа. Тэр бол би түрүүнд хэлсэн Монгол Улсын Засгийн газрын хүрээнд батлагдаад хэрэгжиж байгаа энэ олон улсын Дэлхийн банк болон Азийн Хөгжлийн банкны энэ зээлүүдийг бид дараагийн үе шатыг нь хэрэгжүүлэх энэ бэлтгэл ажил руугаа бол орж байгаа. Тэгэхдээ энэ зээлийг олгохдоо бид нар энэ Хүнсний хувьсгал, Цагаан алт гээд энэ хөтөлбөрүүдийн хүрээнд экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлж чадаж байгаа энэ үйлдвэрүүдийг олон улсын стандартад нийцсэн энэ бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болох, түүнийгээ олон улсад гаргах энэ бололцоог нь өшөө илүү дэмжиж өгөх нь зүйтэй юм гэсэн ийм бодлоор бас байгаа.

“Нутагтаа эзэн 100:1000” гэдэг энэ хөтөлбөр бол товчхондоо хэлэх юм бол мал аж ахуйнд тулгамддаг энэ отор, нүүдэл, өвчин, ган, зуд гээд олон бэрхшээлүүдийг давахад малчид бэлтгэл, бэлэн байдлаа хангах ийм л бололцоог төр олгож, иргэд олон нийт өөрсдөө үүн дээр идэвх санаачилгатай оролцож явах хамтын ажиллагааны ийм том хөтөлбөр байгаа. Би түрүүнд хэлсэн 5 сарын 25 гээд энэ зөвлөгөөнүүд бид аль болох хурдхан шиг хийгээд дуусгахыг зориод үүнийхээ ард дээр бид нар Байнгын хорооныхоо гишүүдэд бас танилцуулна гэж байгаа. Тэр үеэр өшөө дэлгэрэнгүй танилцуулна.

Эцэст нь Хангайн бүс ийн энэ хөдөө аж ахуйн сайд хэдийгээр миний хувьд зүүн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүн гэлээ. Гэхдээ би Засгийн газрын гишүүн, салбарын сайд гэдэг.../минут дуусав./

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн гүйцээж хариулъя.

**Ц.Идэрбат:** Салбарын сайд энэ хариуцлагаа бол ухамсарлаж байгаа. Тийм учраас аль нэгэн бүс гэдэг юм уу, аль нэгэн аймаг гэдэг тийм зүйл бол гаргахгүй. Бид 5 сарын 11-нд Хэнтий аймагт зүүн бүс хийсэн. Энэ 5 дахь өдөр бол говийн бүсээ хийнэ. 18-нд Өвөрхангайд хийнэ. 20-нд Ховдод хийнэ. 23-нд Булганд буюу хойд бүсээ хийнэ. 25-нд Дархан-Уул аймагт хийгээд ингээд дуусна. Тэгээд эндээс гарч байгаа олон саналуудыг бид бас 2027 оны энэ төсөл, хөтөлбөр рүүгээ бас

үнийн дүнгийн хувьд ч гэсэн оруулах бололцоог гаргахын тулд хөгжлийн хөтөлбөр дээр бас зарим зүйлүүдийг бол урьдчилаад төсвийг нь тавиагүй ч гэсэн оруулах зайлшгүй шаардлага байна.

Төсвийн эх үүсвэрийг бид нар зөвхөн улсын төсвийн гэж харахгүйгээр зээл, тусламж, хөтөлбөрүүдийг ч гэсэн энэ зүйлүүд рүүгээ бас хандуулъя гэсэн ийм байдлаар төлөвлөсөн гэдгийг бас танд нэмж хэлье. Баярлалаа.

**Б.Бейсен:** Батчимэг гишүүн тодруулъя.

**П.Батчимэг:** Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид бол үнэхээр улс оронд энэ Монгол Улсын эдийн засаг тэгээд ерөөсөө хамаг ачааг бол нуруундаа үүрч явж байгаа дундаж давхаргын хүмүүс л дээ. Тэгэхээр би тэр яриад л байгаа энэ яг энэ зээл авч байгаа энэ 100 тэрбумын санхүүжилт авч байгаа энэ бизнес эрхлэгчид чинь энэ хөнгөлөлттэй зээлээ яг хугацаанд нь авч чадах юм уу? Ямар шалгуураар? Тэр олон мянган цаас бэлтгэж хүлээх хугацаа энэ юмнууд зээлийн тэр хүү хэр уян хатан байх юм энэ тэр гээд энэ дээр бүүр нэгдсэн ийм бүүр шатлалтай юунуудыг гээд асуугаад байгаа юм. Тэгээд тэр дээр би их нэлээн юу авч чадсангүй. Тодорхой хариулт авч чадсангүй танаас.

Ер нь өнгөрсөн оны юун дээр бас л тэр малын, бэлчээрийн усан хангамж гэж яриад л 100 худаг гээд л тавиулсан санагдаад байх юм өнгөрсөн жил. Тэгвэл одоо дахиад л бас энэ худаг орж ирж байна шүү дээ. Тэгээд яг түрүүн.../минут дуусав./

**Б.Бейсен:** Идэрбат сайд хариулъя.

**Ц.Идэрбат:** 3 тэрбум сая жижиг, дунд үйлдвэрийн асуудал дээр бол Батчимэг гишүүнтэй санал нэг байна. Би сая хэлсэн хугацааг нь 5 жил байсныг 8 жил болгосон. Эргэн төлөлтийг эхний жил нь байхгүй болгож байгаа.

Нөгөө талдаа зээл олгох процессыг маш шуурхай болгож байгаа. 3, 4 сар дамждаг, 4, 5 шат дамждаг байсан зүйлийг 20 хоногийн дотор шийддэг болж байгаа. Тэгээд манай жижиг, дунд үйлдвэрийнхэн бол нэлээн ачаалалтай ажиллана. Гэхдээ энэ бол бас бид манай улсын хувьд бол онцлогтой. Энэ хавраас эхлээд бизнес идэвхэждэг. Энэ үед нь зээлийг нь олгоод 30 хоногийн дотор олгоод дуусчихъя гэсэн ийм чигтэй байгаа.

Бэлчээрийн усан хангамжийн асуудал бол яах вэ жилийн жилд л энэ яамны төсөв дээр тавигдаад явдаг. 2026 онд 3.3 тэрбум төгрөгөөр 108 худаг гаргах ажил сонгон шалгаруулалтад орлогдоод явж байгаа. Тэгээд цаашдаа жил болгон ингээд бага багаар нэмэгдүүлээд л ингээд л явдаг тэр төсөв л тавигдчихаад явж байгаа гэж ойлгож болно.

**Б.Бейсен:** Гишүүд асуугаад дуусаж байна.

Би нэг санал хэлье гэж бодож байна. Ер нь малын түүхий эд боловсруулах үйлдвэр барина гээд олон жил ярьж байна. Идэрбат сайд ч ярьж байна малын арьс шир, нэхий, ноос энэ тэр үнэгүйдэж хаягдаж байна. Баруун 5-н аймгийн малын нооснуудыг цуглуулж Баян-Өлгий аймагт том ноос хуваах үйлдвэр байсан соц нийгмийн үед. Энийг хувьчилж аваад гадаадын компани зарчихсан. Одоо банканд 2.6 тэрбумын барьцаанд байгаа. Ноос цуглуулах цэгтэй, хадгалах цэгтэй,

угаах цэгтэй, самнах цэгтэй, пресслэх цэгтэй ийм том үйлдвэр бэлэн байж байгаа юм. Энийг бас том компаниуд энэ Эдийн засаг, хөгжлийн яам, Хөдөө аж ахуйн бас санал болговол баруун 5 аймгийн ноос энэ тэрийг угааж байсан том ноос угаах үйлдвэр шүү дээ.

Нөгөө талаар энэ малын дотор эрхтнийг тэр чигээрээ байгаль орчин бохирдож байгаа асуудал байж байгаа. Тийм учраас энэ хөгжлийн төлөвлөгөөндөө бас энийг тусгах талын асуудал дээр. Яс тэр чигээрээ хаягдаж байна. Органик бордоо гарах боломж байж байгаа. Энэ тал дээр бас хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаад яавал зүгээр байна.

Нөгөө талаар энэ говийн усны асуудал байж байна. Бид нар станы орнууд зарим улс оронтой судалсан урд, хойд хөршөөс. 5, 6, 7, 8 сард усны түвшин нэмэгдэх үед, үерлэх үед нь энийг гаргах арга хэмжээ бол танайд илүү тохиромжтой юм гэдэг асуудал тавьсан тэд нар. Яагаад гэвэл өвөлдөө хүйтэн байдаг. Тэгэхгүй бол бас олон улсын хууль, конвенц энэ тэр зөрчих асуудал гардаг. Тэр тал дээр анхаараарай гэсэн. Тэрийг бас хөгжлийн төлөвлөгөөнд бас сийрүүлэх нь зөв байх гэсэн санал хэлье.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөтэй холбоотой байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, яамдын сайдууд, ажлын хэсгийнхэнд баярлалаа гэж хэлье. Хуралдаан дууслаа.

18.30 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

